



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2021 • № 59



ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙГ
ДЭМЖИХЭД ТӨВ
БАНКНЫ ҮҮРЭГ,
ОРОЛЦОО

УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
СӨРӨГ
НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХАД
ТӨР, ХУВИЙН
ХЭВШЛИЙН
ХАМТЫН
АЖИЛЛАГАА
ЧУХАЛ ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭНЭ

Тайлбар: Монголбанкны Эрдэнэсийн сан дахь
Чандмань эрдэнэ

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Огноо: 2021/12/16

Бодлогын хүүг хэвээр хадгалах, санхүүжилтийн хэмжээг тогтоох тухай

Дугаар: 2021/04

Огноо: 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны ирээдүйн төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. 2022 оны 1 дүгээр улирлын Урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр тогтоох;
3. Репо санхүүжилтийн хүүг бодлогын хүү+0.5 хувиар тогтоох;
4. Гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлж 18 хувьд хүргэх багц шийдвэрийг гаргалаа.

Жилийн инфляц 2021 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 10.5 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 10.0 хувьд хүрэв. Хилийн хязгаарлалт, малын халдварт өвчний тархалт, тээврийн зардлын өсөлт зэрэг нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт инфляцын дийлэнхийг бүрдүүлж байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц ойрын хугацаанд өсөх хэдий ч 2022 оны сүүлийн хагаст Төв банкны зорилтын орчимд тогтворжих төсөөлөл гарч байна. Гэвч нийлүүлэлтийн сүлжээний саатал, хилийн хязгаарлалт, хүнс, шатахууны үнийн хүлээлтээс давсан өсөлт зэргээс шалтгаалан инфляц хурдан буурахгүй байх эрсдэлтэй байна. Иймд урт хугацаат репо санхүүжилтийн зориулалтыг өргөтгөн шатахуун болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг шаардлагатай түвшинд хүртэл бүрдүүлэхэд ашиглаж болохоор шийдвэрлэлээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт нэмэгдэж, экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд хадгалагдаж байгаа боловч, дотоод эдийн засгийн өсөлт сүүлийн 2 улиралд төсөөллөөс доогуур гарлаа. Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ эдийн засгийн идэвхжил, сэргэлтэд эерэг нөлөөтэй байгаа хэдий ч өрхийн хэрэглээ сэргэхгүй, хилийн хязгаарлалттай холбоотойгоор гадаад худалдаа, нийлүүлэлтийн хангамж тасалдаж, улмаар тээвэр, боловсруулах, барилгын салбарт идэвхижил сул байгаа нь эдийн засгийн өсөлт өмнөх улирлаас саарахад голлон нөлөөлөв. Бодлогын хүүг одоогийн түвшинд хэвээр хадгалах нь эдийн засгийн сэргэлтийг тэтгэх, өсөлтийг тогтворжуулахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Түүнчлэн, Мөнгөний бодлогын хорооноос банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор гадаад валютын заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэлээ.

Төв банк эдийн засгийн сэргэлт болон инфляцын төлөвтэй уялдуулан мөнгөний бодлогын тохиргоог тухай бүр хийх болно.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

“ДЭЛХИЙН
ХУРИМТЛАЛЫН ӨДӨР
-21” АЯНЫГ ОРОН
ДАЯАР ТЭМДЭГЛЭВ



10

БАЙР СУУРЬ

УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
ЭСРЭГ ТЭМЦЭХЭД
ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГУУДЫН
БАРИМТАЛЖ
БУЙ БАЙР СУУРЬ



18

АСУУЛТ, ХАРИУЛТ

МОНГОЛБАНКНЫ
ХЭВЛЭЛИЙН
ХУРЛААС



29

СУДАЛГАА

НҮҮРСТӨРӨГЧИЙН
ЯЛГАРЛЫГ ЦЭВЭР
ДҮНГЭЭР ТЭГ (NET
ZERO) БАЙЛГАХ
ЗОРИЛТ: МОНГОЛ
УЛСАД АНХААРАХ
АСУУДЛУУД



07

ИНДЭР

ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙГ
ДЭМЖИХЭД ТӨВ
БАНКНЫ ҮҮРЭГ,
ОРОЛЦОО



13

НИЙТЛЭЛ

УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХАД ТӨР,
ХУВИЙН ХЭВШЛИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГАА
ЧУХАЛ ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭНЭ



25

МОНГОЛБАНК ЮУ
ХИЙДЭГ ВЭ?

ЦАХИМ МӨНГӨ НЬ
САНХҮҮГИЙН
ХҮРТЭЭМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛНЭ



37

БАНКИР

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ
ХАНГАГДАХАД
НИЙГМИЙН УХАМСАР,
СОЁЛЫН ХАНДЛАГА
ИХЭЭХЭН ХАМААТАЙ

“ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР -21” АЯНЫГ ОРОН ДАЯАР ТЭМДЭГЛЭВ

2021.10.02



Швейцарын Холбооны Улсын Эдийн Засгийн Газар (SECO)-аас хэрэгжүүлдэг Төв банкуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт Монголбанк хамрагдах санамж бичгийг талууд байгууллаа. Санамж бичигт Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Швейцарын Хамтын ажиллагааны газар, Консулын хэлтсийн дарга Стефани Бурри нар гарын үсэг зурав. Энэхүү хөтөлбөрт хамрагдсанаар Монголбанкны мөнгөний бодлогын шинжилгээ, макро-эдийн засгийн судалгаа, статистик, бодлого үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, олон улсын жишигт ойртуулахад дөхөм болох юм. Тус хөтөлбөр нь 2013 оноос хөгжиж буй улс орнуудын Төв банкуудын аналитик болон техник экспертизийг хөгжүүлэхэд зорьжээ. Одоогоор Албани, Азербайжан, Босни ба Херцеговина, Колумб, Морокко, Перу, Тунис, Украин зэрэг улс орон энэхүү хөтөлбөрт амжилттай хамрагдан 54 удаагийн судалгааны ажлыг хийжээ.

РЕПО АРИЛЖААГААР БАНКУУДАД 160 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОЛОО

2021.10.12



Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Монголбанк 2021 оны 4 дүгээр улирлын ээлжит репо арилжаагаар Төв банкнаас 285 тэрбум хүртэл төгрөгийн эх үүсвэрийг зарлаж, 4 банкнаас нийт 160 тэрбум төгрөгийн репо санхүүжилт авах санал ирүүлснийг Монголбанк бүрэн биелүүллээ. Уг санхүүжилтээр банкууд жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспорт, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, хоёр зуу болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээдэд зээл олгогдож байгаа юм.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

2021.10.21



Монголбанкны Хяналтын зөвлөл (МБХЗ)-ийн ээлжит хурал болж, Монголбанкны эрсдэлийн удирдлага ба дотоод аудитын үйл ажиллагааны уялдаа, өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл сонслоо. Мөн Төв банк (Монголбанк)-ны 2018 онд шинэчлэгдсэн хуулийн дагуу байгуулагдсан Хяналт шалгалтын хорооны үйл ажиллагааны хараат бус, хөндлөнгийн хяналттай байх зарчмыг судалж үзэх, Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ (Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага)-ын зөвлөмжийн хэрэгжилтийн нөхцөл, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл сонсож, санал солилцлоо.

“ТИНК БАНК” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД МОНГОЛБАНКНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ Г.ЭНХТАЙВАН МУИС-ИЙН ОЮУТНУУДАД ЛЕКЦ УНШЛАА

2021/11/01



Эдийн засаг, санхүүгийн чиглэлийн судалгаа, сургалтыг дэмжих “Тинк-банк” хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, МУИС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхим болон Нийгмийн ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн оюутнуудад “Финтек ба Криптовалют” сэдвээр лекц уншиж, чөлөөт ярилцлагыг өрнүүлээ. Монголбанкны хувьд Тинк-Банк хөтөлбөрөөс гадна “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг манлайлан хэрэгжүүлж байгаагийн нэг зорилтот бүлэг нь их дээд сургуулийн оюутнууд юм. Энэ хөтөлбөрийн үр дүнд магадлан итгэмжлэгдсэн 11 их дээд сургуульд “Хувь хүний санхүү” хичээлийг мэргэжил харгалзахгүй үзэж байна.

○ ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТЫГ ЧИП ТЕХНОЛОГИД ШИЛЖҮҮЛЛЭЭ

2021/11/11



Монголбанк төлбөрийн системийг хөгжүүлэх, боловсронгуй болгох зорилтын хүрээнд банкуудтай хамтран соронзон туузтай ₮ картыг олон улсын жишигт нийцсэн EMV чип технологид амжилттай шилжүүллээ. Ингэснээр соронзон туузтай картын мэдээллийг хуулбарлах, дуураймал картаар гүйлгээ хийх эрсдэл буурч, ₮ картын нууцлал, аюулгүй байдал сайжирч, картыг зайнаас уншуулах боломжтой болохын зэрэгцээ карт эзэмшигч төлбөр тооцоогоо чиптэй картаар гүйцэтгэхэд илүү хялбар, хурдан болж байна. Түүнчлэн, чиптэй ₮ картад суурилсан QR кодоор гүйлгээ хийх, ₮ картын мэдээллийг токенжуулах (tokenization) суурь тавигдлаа. Мөн, карт эзэмшигч ₮ картаараа нийтийн тээвэр, автомашины зогсоол, замын төлбөр гэх мэт үнийн дүн багатай гүйлгээнд пин код ашиглахгүйгээр картаа зайнаас уншуулж төлбөр тооцоогоо хийх боломж бүрдэж байна.

○ МОНГОЛ УЛСЫН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ III УЛИРЛЫН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛОВ

2021/11/12



Терроризмтой тэмцэх зөвлөлийн ээлжит хуралдааныг Терроризмтой тэмцэх зөвлөлийн дарга, хошууч генерал П.Одонбаатар удирдаж, зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг төрийн 22 байгууллагын удирдлагууд оролцлоо. Тус хуралдааны эхэнд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн танилцуулгыг Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван хийлээ. Мөн энэ үеэр Виртуал хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, түүний зохицуулалт болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр, стратегийг Санхүүгийн мэдээллийн албаны дарга Б.Батбаатар тус тус танилцуулав.

○ МОНГОЛБАНКНААС ТӨЛБӨРИЙН КАРТ ГАРГАХ, ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ

2021/11/17



Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А-233 дугаартай тушаалаар Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд болон Төлбөрийн картын журамд заасан шаардлагыг хангасан Гурван зуун жар финанс ББСБ ХХК-д "₮ карт" төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргах, "₮ карт", Юнионпэй (UnionPay) төлбөрийн картыг хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаагаар олголоо.

ФИНТЕК КОМПАНИУДАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

2021/11/18



Монгол Улсад хоёр шатлалт банкны систем үүсч хөгжсөний 30 жилийн ойг тохиолдуулан Монголбанк, Монголын Банкны холбоотой хамтран финтек компаниудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, санал солилцлоо. Уулзалтаар Монголбанкны зүгээс авч хэрэгжүүлж буй эрх зүйн орчны шинэчлэл, хяналт зохицуулалт болон төлбөрийн системийн дэд бүтцийн шинэчлэлийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, финтек байгууллагуудын саналыг сонсов. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2018 оноос хэрэгжиж эхэлснээр төлбөрийн системд банкнаас бусад хуулийн этгээд оролцох боломжтой болсон бөгөөд энэ хугацаанд нийт 16 финтек байгууллага Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа явуулж байна.

"САНХҮҮГИЙН САЛБАРТ УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ" СЭДЭВТ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

2021/11/24



"Монголын тогтвортой санхүүгийн форум-2021"-ийн хүрээнд Монголбанк, ТоС холбоо, Олон Улсын Санхүүгийн корпорац (ОУСК) хамтран "Санхүүгийн салбарт уур амьсгалын эрсдэлийг үнэлэх нь" сэдэвт салбар хэлэлцүүлгийг цахимаар зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгийн үеэр Дэлхийн банк, ОУСК-аас "Санхүүгийн салбарт уур амьсгалын эрсдэлийг үнэлэх нь" сэдвийн хүрээнд зохицуулагч байгууллага болон санхүүгийн байгууллагуудын анхаарах зүйлсийн талаар хэлэлцүүлэв. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн баримт бичигт "Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх" талаар тусгаад буй. Монголбанк уур амьсгалын өөрчлөлт, түүний санхүү, эдийн засгийн салбарт нөлөөлөх нөлөөллийн талаар холбогдох судалгааг хийж, төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах юм.

БАНКНЫ АЖИЛТАНД ТАВИГДАХ СУУРЬ ШААРДЛАГЫН ЖИШГИЙГ БАТАЛЛАА

2021/11/30



2020 оны 12 дугаар сард Монголбанк, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, Монгол Улсын банкны салбарт ажиллах ажилтнуудад тавигдах нэгдсэн суурь шаардлагыг бий болгож, арилжааны банкуудаар мөрдүүлэх зорилготой хөтөлбөрийг эхлүүлж байв. Үүний үр дүнд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Банкны ажилтанд тавигдах суурь шаардлагын "жишиг" –ийг баталлаа. Банкууд цаашид нийт арилжааны банкууд сайн дурын үндсэн дээр өөрсдийн ёс зүйн дүрэм, дотоод бодлого, үйл ажиллагаандаа нийцүүлэн хэрэгжүүлэх боломжтой юм. Шинэ банкирын жишиг суурь шаардлагыг хангуулах онол-практик хосолсон сургалтыг ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сангийн ноу-хауд тулгуурлан, Банк санхүүгийн академиас шат дараатайгаар ирэх оноос эхлэн хэрэгжүүлнэ.

М 2021



Монголбанкны Ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэнгийн
“Монголын тогтвортой санхүүгийн
форум-2021”-д хэлсэн үг
2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХЭД ТӨВ БАНКНЫ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

*Тогтвортой санхүүгийн форумд оролцож буй эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид
Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!*

Дэлхий нийтэд цаг уурын өөрчлөлт бодитоор бий болж, түүний сөрөг нөлөө улам бүр нэмэгдэж байна. Манай орны хувьд сүүлийн 80 жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.25°C-ээр нэмэгдсэн. Энэ нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр үзүүлэлт бөгөөд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эрсдэлтэй орнуудын нэг болоод байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цаг агаарын гамшигт үзэгдлийн тоо манай оронд сүүлийн 20 жилд хоёр дахин нэмэгдсэн статистик байна. Цаг агаарын дулаарлаас үүдэн өвөл унах хур тунадасны хэмжээ үлэмж нэмэгдэх, зун илүү хуурайших нөхцөл байдал бий болж байна. Тухайлбал, манай орны нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь, нийт бэлчээрийн 57 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн, бэлчээрийн ургац 20-30 хувиар буурсан, нийт газар нутгийн 90 орчим хувь нь хуурай болон хагас хуурай газрын эмзэг экосистемээс бүрддэг зэрэг эрсдэлт хүчин зүйлс өндөр юм. Энэ нөхцөл байдал нь манай орны мал аж ахуй, газар тариалангийн салбарт бодитоор нөлөөлж эхэллээ. Иймд дэлхий нийтийн цаг уурын өөрчлөлтийг бууруулах чиглэлд хэрэгжүүлж буй үүрэг, амлалтад Монгол Улс хувь нэмэр оруулах

зайлшгүй шаардлага үүсэж байна. Тэр дундаа, төр, хувийн хэвшил нягт хамтран байгаль орчны доройтолтой тэмцэх шаардлага зүй ёсоор тулгарлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэсний Байгууллагын Суурь конвенцын оролцогч талуудын XXVI бага хуралд оролцож, 197 орны хамтаар Глазгогийн гэрээ хэлэлцээрийг хамтран тохиролцсон. Монгол Улс “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” бичиг баримтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан болж буй хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувь хүртэл бууруулахаар тодорхойлсон. Энэ үеэр дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж, шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар дээрх зорилтоо ахиулах боломж байгааг ч мөн дуулгасан.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх арга хэмжээг дотор нь 1/ Эрсдэлээс сэргийлэх /Mitigation/ буюу агаар дахь хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах замаар цаг уурын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, 2/ Дасан зохицох /Adaptation/ буюу уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг урьдчилан харж, хохирлыг бага байлгах

чиглэлд арга хэмжээ авах гэж хоёр ангилдаг.

Эдгээр 2 арга хэмжээ нь санхүүгийн салбартай нягт холбоотой. Цаг уурын өөрчлөлтийг бууруулах арга хэмжээний хувьд санхүүгийн салбар нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай эх үүсвэрийн хуваарилалтад чухал үүрэг гүйцэтгэж чадна. Өөрөөр хэлбэл, хүлэмжийн хийн эх үүсвэрийг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх, бага бохирдол ялгаруулах тээврийн хэрэгслүүдтэй болох, хүлэмжийн хийг өөртөө шингээх ой модны хэмжээг нэмэгдүүлэх зэрэгт санхүүжилт шаардлагатай.

Харин дасан зохицох арга хэмжээний хувьд цаг уурын өөрчлөлт нь санхүүгийн системд 2 үндсэн сувгаар нөлөөлнө. Эхнийх нь, биет эрсдэл буюу цаг уурын өөрчлөлтөөс үүдэн үл хөдлөх хөрөнгө, дэд бүтэц болон газар эвдэрч, сүйрэхтэй холбоотой эрсдэл юм. Энэ нь санхүүгийн байгууллагуудын активын хойно байгаа барьцаа хөрөнгийн үнэлгээ унах байдлаар томоохон эрсдэл бий болгоно. Хоёрдахь нь, шилжилтийн эрсдэл буюу нүүрс төрөгч бага ялгаруулдаг эдийн засаг руу шилжих шилжилтийн үед баримтлах цаг уурын бодлого, технологи болон хэрэглэгчийн зан төлөв, зах зээлийн хүлээлтэд гарах өөрчлөлтөөс үүсэх эрсдэлүүд юм. Ялангуяа, Глазгогийн тохиролцоонд уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их хувь нэмэр оруулж буй нүүрсийг онцгойлон дурдсан бөгөөд 40 гаруй улс нүүрснээс бүр мөсөн татгалзахаар амлалт өгсөн. Энэ нь нийт экспортын 1/3-ийг нүүрсний экспортоос бүрдүүлж буй манай орны хувьд шилжилтийн эрсдэл өндөр байхыг анхааруулсан дохио боллоо. Өөрөөр хэлбэл, экспорт, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, эрдэс түүхий эдээ боловсруулах, ногоон эдийн засаг руу шилжих ажлыг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дэлхий дахинд төв банкууд, санхүүгийн зохицуулагч байгууллагуудын хувьд цаг уурын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг хяналт шалгалт, санхүүгийн тогтвортой байдлын мониторинг хийхэд тусгах ёстой гэдэг дээр санал нэгдээд байна. Энэ хүрээнд санхүүгийн системийн болон санхүүгийн байгууллага тус бүрийн стресс тест хийхэд цаг уурын өөрчлөлтийн хувилбар шинжилгээнүүдийг оруулан тооцох, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч нэмэлт буфер нөөц байгуулах, зарим шалгуурыг чангаруулах зэрэгт анхаарал хандуулж эхэллээ. Одоогоор 75 гишүүн, 13 ажиглагчтай Ногоон санхүүгийн системийг бүрдүүлэх төв банкууд болон хянан шалгагч нарын сүлжээ (NGFS), 19 орныг эгнээндээ багтаадаг Европын холбооны төв банкин дээр цаг уурын өөрчлөлтийн компаниуд, банкуудад үзүүлэх үзүүлэх нөлөөллийн стресс-тест хийх ажил ахицтай байна. Өнөөдрийн Форумын “Санхүүгийн салбарт уур амьсгалын эрсдэлийг үнэлэх нь” салбар хэлэлцүүлэг 11 дүгээр сарын 24-ны өдөр амжилттай зохион байгуулагдсан.

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Өнөөдрийн форум “Эерэг өөрчлөлтийг санхүүжүүл!” гэсэн уриан доор зохион байгуулагдаж байгаа тул цаг уурын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах буюу тогтвортой санхүүжилтийг дэмжих чиглэлд Монголбанкнаас баримталж буй бодлого, цаашид төлөвлөж буй арга хэмжээний талаар Та бүхэнтэй мэдээлэл хуваалцъя.

Хүлэмжийн хийг бууруулах, дасан зохицох арга хэмжээний хүрээнд санхүүгийн салбарын үүрэг, оролцоог тодорхой болгох, санхүүгийн салбар дах эрсдэлүүдийн нөлөөг урьдчилан тооцож, хариу арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.



Монголбанк тогтвортой санхүүжилтийн чиглэлээр гарч буй олон санал санаачилга, ажлуудыг эхнээс нь дэмжин, хамтран хэрэгжүүлж ирснийг энд онцлон хэлье. Тухайлбал, ногоон эдийн засгийн үйл ажиллагааны ангилал болох Ногоон таксономийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд 2019 оны 12 дугаар сард оруулан батлуулж, энэ ангилал дээр үндэслэн Ногоон зээлийн статистик мэдээллийг энэ оноос албан ёсоор гаргаж эхлээд байна. Ингэснээр банкуудын ногоон зээлийн статистикийг албан ёсоор гаргаж буй цөөн улс орнуудын нэг болсон. Эдгээр арга хэмжээний үр дүнд ногоон санхүүжилтийг аль салбарт чиглүүлэх бодлогын хөшүүргийг гаргах, бодлого, арга хэмжээний үр дүнг тоон утгаар хэмжих суурь нөхцөл бүрдээд байна. Түүнчлэн тогтвортой санхүүжилтийг дэмжих зорилгоор гадаадаас ногоон зээлийн зориулалтаар татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг Монголбанкт урт хугацаат своп хэлэлцээрийн хүрээнд солилцох тохиолдолд 0.5 нэгж хувийн хүүний урамшуулал олгохоор Гадаад валютын своп арилжааны журамд тусгав. Түүнчлэн жендэрийн мэдрэмжтэй санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлд салбарын холбоод, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд банкны салбарын гол статистик мэдээллийг хүйсээр ангилан гаргаж, нийтэд мэдээлж эхэллээ.

Одоо хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг улам өргүүлж, олон улсын сайн туршлагыг нутагшуулах үүднээс Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлд “Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх” заалтыг Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлэхээр тусгаж, Улсын Их Хурал (УИХ)-аар

батлуулаад байна. Энэ хүрээнд 1/Олон улсын санхүүгийн байгууллагууд, төрийн агентлагууд, мэргэжлийн холбоод болон санхүүгийн байгууллагуудтай хамтран өргөн цар хүрээтэй судалгаа хийх, 2/Тогтвортой санхүүжилтийн таксономи, Тогтвортой хөгжлийн нэгдсэн санхүүжилтийн стратегийг эцэслэн боловсруулж, батлахад хамтран ажиллах, 3/ Тогтвортой санхүүжилтийн хүрээнд эх үүсвэр бүрдүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогын хөшүүргийг тодорхойлж, хэрэгжүүлэх, 4/ Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой санхүүжилтийн ойлголт, мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зэрэг ажлыг төлөвлөөд байна. Төв банкны оролцоо, манлайллыг хангах, нэгдсэн Hub бүрдүүлэх үүднээс бусад орны төв банк, санхүүгийн байгууллагуудын сайн туршлага, жишгийн дагуу тухайлсан чиг үүрэг бүхий нэгжийг Монголбанкинд байгуулахаар төлөвлөж байна.

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахын тулд хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх чиглэлд мод тарьж ургуулах, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах дэвшилтэт технологи, инноваци, ноу-хауг нэвтрүүлэхийн аль алинд санхүүжилтийн тогтвортой механизм, бодлогын хөшүүрэг, дэмжлэг чухал үүрэгтэй. Иймд энэ механизмыг төр, хувийн хэвшлийн оролцоог хангасан байдлаар бүрдүүлэх чиглэлд холбогдох талуудтай хамтран идэвхтэй ажиллаж байна.

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Энэхүү Форумын үйл ажиллагаанд амжилт хүсэхийн ядамд Монголбанк тогтвортой санхүүжилтийг дэмжих чиглэлд хувийн хэвшил, төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахад үргэлж нээлттэй байгааг дахин тэмдэглэн хэлье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.





United Nations

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ ТЭМЦЭХЭД ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БАРИМТАЛЖ БУЙ БАЙР СУУРЬ



Монгол Улсын Ерөнхийлөгч
У.ХҮРЭЛСҮХ

МОНГОЛ УЛС

Уур амьсгалын өөрчлөлтөд ихээр өртөж буй орнуудын нэг болох Монгол Улс хүлэмжийн хийг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн чармайлтыг бүрэн дэмжиж, Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхийн төлөө бүх боломж нөхцөлөө дайчлан ажиллах болно гэдгээ дахин нотолж байна. Монгол Улс “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” бичиг баримтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан болж буй хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувь хүртэл бууруулахаар ахиулан тодорхойллоо. Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашлаад Зүүн хойд Азийн эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор Азийн супер сүлжээ санаачилгыг дэмжиж байгаа билээ. Энэ хүрээнд говийн бүсийн нар, салхины арвин нөөцдөө тулгуурлан томоохон эрчим хүчний цогцолбор байгуулахаар бүс нутгийн орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.



Хятадын цаг уурын өөрчлөлтийн
асуудал хариуцсан элч
XIE ZHENHUA

ХЯТАД УЛС

Дэлхийн нүүрсний цахилгаан станцуудын тал хувь нь БНХАУ-д байдаг хэдий ч бусад улс орнуудаас илүү сэргээгдэх эрчим хүчний байгууламжтай юм. Иймд COP26 уулзалтад БНХАУ ногоон эрчим хүч рүү шилжих ажлыг түргэтгэж, сэргээгдэх эрчим хүчийг эрчимтэй хөгжүүлэхээ мэдэгдээд зогсохгүй ногоон шилжилтийг эрчимжүүлж эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийг байгаль хамгаалалтай уялдуулан шинжлэх ухаан, технологи, инновацийг ашиглах нь чухал байна.



UN CLIMATE CHANGE

Шотландын Глазго хотноо НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх 26 дахь удаагийн бага хурал түвшний 26 дахь удаагийн бага хурал 10 дугаар сарын 31-ээс 11 дүгээр сарын 12 хүртэл үргэлжилэв. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш тус уулзалтыг нээж хэлсэн үгэндээ Манай дэлхий хэрхэн өөрчлөгдөж буйг онцлоод зогсохгүй дэлхийн улс орнуудын удирдагч нарт хандан үүний эсрэг яаралтай арга хэмжээ авч эхлэхийг уриалсан юм. Уг хуралд 200 гаруй улс орны 40,000 гаруй зочид, төлөөлөгчид оролцож, энэ үеэр улс орнууд хоёр долоо хоног хэлэлцээр хийсний үндсэн дээр уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах шинэ хэлэлцээрт хүрч гарын үсэг зурсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх тус уулзалтад оролцож, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг өөрийн орны байр илэрхийлсэн билээ.



ОХУ-ын Ерөнхийлөгч
ВЛАДИМИР ПУТИН

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Уг уулзалтад оролцоогүй ч 2021 оны 10 дугаар сарын 11-нд Москва хотод болсон эрчим хүчний талаар хэлэлцэх бага хурлын үеэр ОХУ 2060 он гэхэд нүүрс төрөгчгүй эдийн засагт шилжих зорилт дэвшүүлж буйг онцолсон байна. Энэхүү зорилт нь ойн экосистем болон бусад экосистем, тэдгээрийн нүүрстөрөгчийн давхар ислийг шингээж, хүчилтөрөгч ялгаруулах чадварыг ашиглах төлөвлөгөөн дээр суурилсан гэдгийг дурджээ. Түүнчлэн ой модоо хамгаалах тал дээр шаргуу арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд нөхөн сэргээлтийн ажлыг идэвхжүүлж энэхүү ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж байна хэмээн хэлжээ.



Канадын Ерөнхий сайд
JUSTIN TRUDEAU

КАНАД УЛС

Канадын үндэсний хэмжээнд ногоон эдийн засгийг дэмжих эрхзүйн орчин нь харьцангуй боловсронгуй байдаг. Ногоон эдийн засгийг дэмжих ажлын хүрээнд 2030 он гэхэд нүүрсний хэрэглээг бүрэн халах, 2040 он гэхэд 100% цахилгаан автомашин, 2050 он гэхэд 100 хувь сэргээгдэх эрчим хүчнээс татгалзана гэсэн зорилготой ажилч байна. Түүнчлэн ойжуулалт, байгаль орчны нөхөн сэргээлт, сэргээгдэх эрчим хүч, нүүрстөрөгчийн хий багатай дэд бүтэц гэх мэт ажлууд дээр татварын хөнгөлөлт олгохоор шийдсэн.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд Монголбанкнаас МУ-ын ЗГ, СЗХ-той хамтран хэрэгжүүлэх зорилт

Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

Стратеги

- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийн шинжилгээ, тооцоо судалгааг хийж гүйцэтгэнэ.
- Монгол Улсын дунд ба урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгагдсан зорилтуудтай уялдуулан Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн стратеги, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, санхүүгийн салбарт нэвтрүүлнэ.
- Төрийн байгууллага, институциуд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг бууруулах чиглэлээр нягт уялдаатай хамтран ажиллана.
- Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой санхүүжилтийн ойлголт, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн анхаарлыг нэмэгдүүлнэ.
- Тогтвортой санхүүжилтийн хүрээнд гадаад зах зээлээс эх үүсвэр босгох чиглэлээр ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эдийн засаг, салбаруудад үзүүлж болох нөлөө, учирч болох эрсдэлийн шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, тоон мэдээний чанарыг сайжруулах;
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад чиглэсэн зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн талаар баримтлах бодлого, стратеги боловсруулах;
- Төрийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах чиглэлээр нягт уялдаатай хамтран ажиллах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад харгалзан үзэх;
- Хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүн дээр үндэслэн дараагийн шатны төлөвлөгөө, арга хэмжээг авах;
- Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байгаль орчин, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлдэг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, тусгайлсан шалгуур үзүүлэлт, баталгаажуулалтын аргачлал бүхий Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономи боловсруулах;
- Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд эрчим хүчний хэмнэлттэй болон ногоон барилгыг санхүүжүүлэх тухай заалт, аргачлалыг нэмж оруулах;
- Тогтвортой санхүүжилтийг санхүүгийн байгууллагад амжилттай сайн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв банкны зүгээс авч хэрэгжүүлэх боломж бүхий хөншүүргийн арга хэрэгслүүдийг судалж нэвтрүүлэх;
- Банкны салбарын статистик тайлан мэдээллийг хүйсээр ангилан нийтэд мэдээлэх, гендерийн мэдрэмжтэй санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлд салбарын холбоод, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- Тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээг дэмжиж ажиллах;



Б.БАЯРДАВАА
МОНГОЛБАНКНЫ МБГ-ЫН ЗАХИРАЛ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭНЭ

Уур амьсгалын өөрчлөлт, түүний үр дагаврын талаар бодлого, боловсруулагч, бизнес эрхлэгчдийн түвшинд анхаарах асуудлуудыг юуны өмнө тоймлон авч үзье. Нэгдүгээрт, уур амьсгалын өөрчлөлт нь Монгол Улсын хувьд ирээдүйн биш одоо тулгамдаж буй асуудал болсон байна. Манайд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой сөрөг үр дагаврууд нийгэм, эдийн засгийн амьдралд нэгэнт илэрч байгааг Монгол Улсын дулаарал сүүлийн 80 жилд 2.25°C байгаа нь дэлхийн дулаарлаас 2 дахин өндөр, 6-7 сарууд дахь 26°C хэмээс дээш халуун өдрийн тоо 1990 оноос хойш ойролцоогоор 4 дахин нэмэгдсэн, 5-9 дүгээр сарын хур тунадасны хэмжээ 12.6 мм-

ээр буурсан, үүнийг даган газар нутгийн 77% орчим, бэлчээрийн 57% хувь нь доройтолд орсон зэрэг сөрөг үр дагаврууд илрээд байна. Түүнчлэн, жилийн дундаж гамшигт үзэгдлийн давтамж 1989-1998 оны дундажтай харьцуулахад 29-81 болж, сүүлийн 2009-2018 онд бараг 3 дахин нэмэгдсэн зэргээс харж болно.

Өнөөдрийн байдлаар бодитой тулгарч эхлээд буй эдгээр эрсдэлүүд нь нийгэм, эдийн засгийн өсөлтөд олон сувгаар нөлөө үзүүлэхээр байна. Юуны түрүүнд мал аж ахуй (МАА), газар тариалангийн салбар, түүний бүтээмжид муугаар нөлөөлж байна. Цаашилбал, уул уурхайн салбарын бүтээмж, тухайн салбарт хийх хөрөнгө

оруулалт, түүний зардалд сөрөг нөлөө үзүүлэх нь тодорхой болж байна.

Эдийн засаг, нийгэмд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлж буй сөрөг нөлөөллийг шууд ба шилжилтийн гэж бүлэглэж байна. Шууд эрсдэл нь байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотойгоор бизнесүүд хөрөнгөө алдах, барьцаа хөрөнгөгүй болох, бүх хөрөнгийг нөхөн сэргээх, дахин бий болгохтой холбоотой зардлууд гарах тухай ойлголт юм. МАА салбарын хувьд зуд болон халдварт өвчнөөр хорогдож буй малын тоо, ган зудтай холбоотойгоор үүсч буй отор нүүдлийн зардал, ургац алдалт зэрэг нь манай улсын хувьд жил бүр учирч

буй хор нөлөөний хамгийн ойрын жишээ юм. Түүнчлэн, агаарын бохирдолтой холбоотой сайжруулсан түлшний түүхий эд зэрэгт улсын төсвөөс 100 гаруй тэрбумын татаас зарцуулдаг нь мөн л шууд эрсдэлийн зардал юм. Товчоор тайлбарлавал, шилжилтийн эрсдэл нь дэлхийн улс орнуудын Засгийн газар, холбогдох төрийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлт (УАӨ)-ийн эсрэг арга хэмжээ авахгүй, хугацаа алдсанаас шалтгаалан учирч болох эрсдэл бөгөөд уг хохирол харьцангуй өндөр байх боломжтой. Шилжилтийн эрсдэл нь бизнес эрхлэгчдийн ашигт ажиллагаа, өрхийн орлогод нөлөөлснөөр эзэлдүүлэгч буюу

хөрөнгө оруулагчдад санхүүгийн эрсдэлийг бий болгоно. Цаашлаад хөрөнгө оруулалт, бүтээмж, харьцангуй үнийн сувгаар дамжин эдийн засагт өргөн цар хүрээнд нөлөөлөх боломжтой. Ялангуяа, Глазгогийн тохиролцоонд УАӨ-д хамгийн их хувь нэмэр оруулж буй нүүрсийг онцгойлон дурдсан бөгөөд 40 гаруй улс нүүрснээс бүр мөсөн татгалзахаар амлалт өгсөн байна. Энэ нь нийт экспортын 1/3-ийг нүүрсний экспортоос олдог манай орны хувьд шилжилтийн эрсдэл өндөр байхыг анхааруулсан дохио боллоо. Өөрөөр хэлбэл, олон улсын хөрөнгийн зах зээл дээр нэвтрэх нэмэлт шаардлагууд,

илүү ногоон санхүүгийн тогтолцоог дэмжсэн шаардлагууд нь нүүрс боловсруулах үйлдвэр, цахилгаан станц, тээвэр, конвэйр, ус ашиглалтын хөрөнгө оруулалтын тухайд ирээдүйн сорилтыг бий болгож, үүний эх үүсвэрийн нэмэлт зардлыг бий болгох нь зөвхөн цаг хугацааны л асуудал болж байна. Эх үүсвэрийн өртгөөс гадна хүлэмжийн хий бага ялгаруулдаг дэвшилтэт технологи нэвтрүүлэх шаардлагатай нүүр тулахаар байна. Түүнчлэн, хүрэн салбараар тэтгэгддэг манай эдийн засгийн хувьд өндөр түвшинд хүрсэн гадаад өрийг дахин санхүүжүүлэх зардал жил ирэх тусам өсөх эрсдэлтэй байна.



Эх сурвалж: NGFS (2020)

Харин өнөөдрийн байдлаар Монгол Улсад эрсдэлийн сценариудыг авч үзэж, тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлүүдээс үр нөлөөг нь тооцоолох, эмзэг байдлаа илрүүлэх, хаана том зардалтай том эрсдэлүүдтэй нүүр тулах вэ гэдгээ тодорхойлох хандлага, тооцооллын аргачлал огт алга байна. Гэтэл энэ нь одооноос эхлээд ирээдүйд юу хийх, ямар хэмжээний төсөв, санхүү хуваарилах гэх мэтийг агуулсан бодлого, стратеги, төлөвлөгөөний үндэс суурь болох юм. Хэдийгээр томоохон эрсдэл учирч болзошгүй үед бид анхаарлаа сул хандуулж байгаа хэдий ч боломж бололцоо бүрэн байна. Өөрөөр хэлбэл, дэлхий нийтээр өрнүүлж буй том аяны хүрээнд Монгол Улс бүх түвшинд татагдан орж, хамтын ажиллагааг өрнүүлэх бололцоотой гэж харж байна. Ирээдүйд ногоон бондын зах зээл эрчимтэй хөгжиж,

хөрөнгийн эх үүсвэрүүд энэ зах зээл рүү нүүж, өндөр хөгжилтэй улс орнууд ногоон шилжилтийг эрчимтэй дэмжих нь тодорхой юм. Ийм учраас дотоодын байгууллагууд ОУ-ын санхүүгийн байгууллагууд, бодлого боловсруулагчидтай нэгдэх, түүнчлэн төрийн байгууллагууд уялдаа холбоотой ажиллавал үр дүнд хүрэх бүрэн боломжтой. Дотоодын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын хувьд илүү ногоон хэлбэрийн санхүүгийн тогтолцоог дэмжих бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх төлөвтэй байна. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2019 онд баталсан ногоон таксономыг жишиг болгон тогтвортой санхүүжилт, ногоон санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй буюу дасан зохицсон, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах нөлөөтэй зэрэг бизнесийн төрлийн тодорхойлолт болон таксономыг

баталж, мөрдүүлэхээс бодлого, зохицуулалтын жишиг тогтож эхлэх учиртай. Ийм төрлийн нэгдсэн ойлголт жишиг бий болгохгүйгээр бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг бий болох боломжгүй юм. Эдгээрт үндэслэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгон, нийгэм, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, засаглалын асуудлыг шийдсэний дараа эрсдэлийн удирдлагын шалгууруудыг харьцангуй урамшуулал бий болгох замаар зохицуулах бололцоо харагдаж байна. Түүнчлэн, уул уурхайн бус экспортыг дэмжих, нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрийн салбарыг дэмжих бодлогод ач холбогдол өгч байгаа үед аль салбарыг дэмжих, ямар технологи нутагшуулах зэргээ ногоон сэргэлт байдлаар авч үзэх нь нэг сумаар хоёр туулай агнахтай адил юм.

2021 оны 3 дугаар улирлын инфляцын тайлан

Гадаад болон дотоод эдийн засгийн ерөнхий төлөв өмнөх төсөөллөөс бага хэмжээгээр муудсан ч цаашид сэргэх хандлага үргэлжлэх хүлээлттэй байна. Эдийн засгийн идэвхжилийг даган эрэлтийн шинжтэй инфляц алгуур нэмэгдэх боловч нийлүүлэлтийн шалтгаантайгаар инфляц эрчимжин өмнөх төсөөллөөс өслөө. Цаашид хилийн хязгаарлалтын нөхцөл байдал, түүнтэй холбогдон эдийн засгийн сэргэлт удааших, зардлын болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляц удаан хугацаанд үргэлжлэх, одоогийн түвшнээс нэмэгдэх эрсдэлтэй байна.

Инфляцын хувьд өмнөх төсөөллөөс нэмэгдэн богино хугацаанд Төв банкны зорилтот интервалыг даваад байгаа ч дунд хугацаанд зорилтын орчимд тогтворжих төсөөлөл хэвээр байна. 2021 оны 11 дүгээр сард инфляц улсын хэмжээнд 10.5 хувь, Улаанбаатар хотод 10.0 хувьд хүрч нэмэгдэхэд нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс голлон нөлөөллөө. Тодруулбал, богино хугацаанд хил, гааль дээр үүссэн импортын хадгалалт, тээвэрлэлтийн зардал, малын халдварт өвчин дэгдсэнээс шалтгаалсан махны үнийн өсөлт, шатахууны үнийн өсөлт, түүний дам нөлөө инфляцыг өсгөх нөлөө үзүүлж байна. Мөн эрэлтийн хүчин зүйлсийн инфляцад үзүүлэх нөлөө эдийн засгийн идэвхжилийг даган аажмаар нэмэгдэх хүлээлт хэвээр байна. Дунд хугацаанд ханш сулрах, дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ өсөх нь инфляцын төсөөллийг бага хэмжээгээр нэмэгдүүлэх ч 2022 оны сүүлийн хагасаас Төв банкны зорилтын орчимд тогтворжих төсөөлөлтэй байна. Цаашид нийлүүлэлтийн, зардлын шинжтэй хүчин зүйлсийн нөлөө саарахгүй байх нь инфляц дунд хугацаанд өндрөөр тогтох болгоомжлолыг үүсгэж байна.

Эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнөх төсөөллөөс буурууллаа. Эдийн засгийн өсөлт уул уурхайн бус салбараас шалтгаалж 2021 оны 3-р улиралд төсөөллөөс бага гарав. Засгийн газар,

Төв банкнаас хэрэгжүүлж буй эрэлтийг дэмжих бодлогын нөлөөгөөр зарим салбарын үйлдвэрлэл өсч байгаа ч хөдөө аж ахуйн салбар малын халдварт өвчнөөс үүдэн хүлээлтээс бага, төсвийн хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл болон хилийн хязгаарлалттай холбоотойгоор гадаад худалдаа, бүтээгдэхүүний татварын бүрдүүлэлт муудаж барилга, тээврийн салбар үйлдвэрлэл удааширан өрхийн хэрэглээ буурахад нөлөөлөв. Энэ хандлага он дуустал үргэлжлэхээр байгаа тул 2021 оны эдийн засгийн төсөөллийг бууруулав. Ирэх онд төсвийн төлөв харьцангуй сулрахаар байгаа нь өсөлтөд эерэг нөлөөтэй боловч гадаад эрэлт, худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын төсөөлөл буурч байгаа нь уул уурхайн бус салбарын идэвхжлийг өмнөх төсөөллөөс сааруулахаар байна. Түүнчлэн, эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв Ковид-19 вирусын шинэ хувилбарын тархалт, хилийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс шууд хамааралтай.

Дунд хугацаанд зэсийн баяжмал, түүний агууламж буурах хүлээлттэй байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлийг бууруулах нөлөө үзүүлэх ч бусад салбарууд цар тахалтай холбоотой уналтаас гарч урт хугацааны хэвийн түвшиндээ хүрэх, мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт сэргэж уул уурхайн бус салбар эрчимжин эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.



Нэгдсэн төсвийн 2021 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 41 хувиар нэмэгдсэн бөгөөд үүний 1 их наяд төгрөг нь Оюутолгойн татварын маргаантай холбоотойгоор бий болсон тооцоолоогүй, нэмэлт орлогоос бүрдсэн бол бусад хэсэг нь эдийн засгийн идэвхжил, татвар бүрдүүлэлт нэмэгдсэнээр бий болсон орлогын өсөлт юм. Харин төсвийн нийт зардал энэ оны 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өссөн хэдий ч төсвийн зардал, тэр дундаа төсвийн хөрөнгө оруулалтын зардал дутуу гүйцэтгэлтэй байна.

Зээлийн өсөлт тогтворжиж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өмнөх улирлаас саарлаа. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж гадаад цэвэр активийн үзүүлэх нөлөө буурсан бол “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор бизнесийн зээл идэвхжсэн хэвээр байгаа нь эерэг нөлөө үзүүлж байна.

Гадаад эдийн засгийн төлөв муудаж, тодорхой бус байдал нэмэгдэж байна. Дэлхий дахинд вакцинжуулалт үргэлжилж байгаа ч Ковид-19 вирусийн шинэ хувилбарын тархалт нэмэгдэж, АНУ болон БНХАУ-ын өсөлтийн төлөв буурсанаас манай гадаад эрэлт өмнөх төсөөллөөс муудлаа. 2022-2023 онд дийлэнх орнуудын өсөлт тогтворжиж, төсөв, мөнгөний бодлого нормалчлагдан, урт хугацааны хэвийн түвшиндээ

орох төлөвтэй байгаа ч КОВИД-19 вирусийн шинэ хувилбарууд тархах, шинэ давлагаа үүсэх, инфляц өсч улс орнууд мөнгөний бодлогын төлөвөө хурдтай чангаруулах нь гадаад орчны гол эрсдэл болж байна.

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр байгаа ч цаашид буурах хандлагатай байна. Түүхий эдийн эрэлт өндөр, нийлүүлэлт хязгаарлагдмал байгаагаас зэс, алт, газрын тосны үнийн төлөв өмнөхөөс сайжирсан бол харин БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл буурч, төмрийн хүдрийн үнийн төлөв өмнөх улирлын хүлээлтээс муудлаа. Мөн БНХАУ-ын байгаль орчны зорилт, 0-КОВИД бодлогын улмаас нүүрсний нийлүүлэлт буурч, нүүрсний үнэ 3-р улиралд огцом өссөн бол эргээд нийлүүлэлт сэргэж, үнэ буурах хандлагатай байна. Улмаар экспортын үнэ импортын үнээс хурдтай өсөж, худалдааны нөхцөл (гадаад худалдааны үнэ) 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирч байгаа бол 2022 оноос эргэн муудна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2021 оны 3 дугаар улиралд -526.0 сая ам.доллар буюу ДНБ-ий 3.7 хувьтай тэнцэх алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 732.7 сая ам.доллараар буурлаа. Тодруулбал, импорт өсч, үйлчилгээ, орлогын дансны алдагдал тэлсний зэрэгцээ экспорт өсөөгүй нөлөөгөөр өмнөх оны мөн үед ашигтай байсан урсгал данс тайлант улиралд өндөр алдагдалтай гарав. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад зээлийн ашиглалт нэмэгдэн, санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдлээ.



Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэр танилцуулах хэвлэлийн бага хурлын тэмдэглэл

Мөнгөний бодлогын хороо 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж, бодлогын хүүг хэвээр хадгалах, 2022 оны 1 дүгээр улиралд репо санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр тогтоох, репо санхүүжилтийн хүүг бодлогын хүү дээр нэмэх нь 0.5 хувь байхаар тогтоох, гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөд заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлж, 18 хувьд хүргэх багц шийдвэрийг гаргалаа. Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлын үеэр Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн асуултад хариуллаа.

Gogo.mn: УИХ-аас Банкны хуулийн хэрэгжилтийг хянах ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэгт Монголбанкнаас орсон уу?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН:

УИХ-аас ажлын хэсэг гарсан гэсэн мэдээлэл бий. Гэхдээ үндсэн ажлын хэсгээс гадна мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн дэд ажлын хэсэг байгуулагддаг. Тус ажлын хэсгийн талаарх мэдээлэл албан ёсоор ирээгүй байна. Яг тэрнийх нь албан ёсны шийдвэр ирээгүй байна. Ерөнхийдөө ажлын хэсэг Банкны тухай хуулийн хэрэгжилт ямар байна вэ гэдгийг шалгах л зорилготой гэж ойлгож байгаа. Оны эхэнд гарсан Банкны тухай хуулийн дагуу эрс шинэчлэлийн шинжтэй зүйл заалтууд хэрэгжихээр байгаа. Томоохон банкууд хувьцаагаа нээлттэй арилжаалж, олон нийтийн хараа хяналттай, оролцоотой болно. Мөн нэг банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч өөр нэг банкны хувьцаа эзэмшигч байж болохгүй. Хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл 20 хувиас хэтрэхгүй байх ёстой. Хуулийг хэрэгжүүлэх талаар өнөөдрийг хүртэл хийж буй ажлууд цаашид нийтэд нээлттэй байх болно.

Gogo.mn: Банкны тухай хуулийн дагуу ирэх онд банкууд IPO хийж, олон нийтээс хөрөнгө татна. Үүнтэй холбоотой дэд бүтэц бэлэн үү, олон хүн захиалга өгөхөд үнэт цаасны бүртгэлтэй холбоотой ачаалал үүсэх, гацах доголдох зэрэг асуудал гарахгүй гэх баталгаа бий юу. Энэ талаар бэлтгэл ажлыг хангаж байгаа юу?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН:

Богд банк нь Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, IPO гаргаад байна. Долоо хоногийн дотор 31.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн. Энэ явцад Монголбанкны зүгээс тодорхой хяналт тавьж, саад бэрхшээл юу байна вэ гэдэг дээр мониторинг хийхэд арилжааны явц, бүртгэл зэрэг дээр ямар нэгэн асуудал гараагүй. Гэхдээ жижиг банк, бага дүнтэй арилжаа явсан учраас асуудал бага гарсан байж болно. Том банк IPO гаргаад, өндөр дүнтэй арилжаанууд явбал, шинээр асуудал үүсэж магадгүй гэж харж байгаа. Тийм учраас бид нөөц төлөвлөгөө гаргасан. Энэ нь Монголбанкны их дүнтэй болон бага дүнтэй гүйлгээний систем бүрэн автоматжисан, олон улсын түвшинд ажиллаж байгаа. Үүнтэй зэрэгцүүлээд, Төв банк бас дэргэдээ үнэт цаасны бүртгэлийн системийг хөгжүүлсэн. Хөрөнгийн биржийн хувьд үнэт цаасны бүртгэл, тооцоо нь Үнэт

цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамждаг. Цаашдаа Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв манай системийг ашиглана гэвэл чөлөөтэй. Мөн ямар нэг хүндрэл учирвал, манай систем дэмжээд ажиллахад бэлэн. Манай систем дээр Засгийн газар үнэт цаасны арилжааны бүртгэл хийгдэж болно. Банкууд IPO гаргаж, бүртгэл хийгдэх боломжтой. Монгол Улсын хөрөнгийн биржээр дамжиж байгаа бүх арилжааны бүртгэлийг хийх бүрэн боломжтой, олон улсын хамгийн сүүлийн үеийн систем юм. Энэ нь Монголбанкны банк хоорондын төлбөр, тооцооны системтэй нийцтэй ажиллаад эхэлбэл, бүр асуудалгүй болно гэж харж байгаа.

NTV телевиз: ОУВС-ийн дүрмийн 4 дүгээр заалтын зөвлөмж гарсан. Үүнд Монголбанктай холбоотой олон зөвлөмж байсны дотор төв банкны бие даасан, хараат бус байдлыг сайжруулах, төсвийн шинжтэй арга хэмжээнээс татгалзах зэрэг асуудлууд багтсан. Энэ зөвлөмжийг Монголбанк хэрхэн авч үзэж байгаа вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН:

ОУВС жил бүр гишүүн орнууддаа гишүүнчлэлийн дөрөвдүгээр заалтын дагуу үнэлгээ хийж, зөвлөмж өгдөг. Үнэлгээний ажлын хэсэг Монгол Улсад хоёр сар гаруй ажиллаад, дүгнэлтээ гаргаж, олон нийтэд нээлттэй мэдээлсэн байгаа. Үүгээр Монгол Улс ОУВС-тай хамтран Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүдээ цааш хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн зөвлөмж өгсөн. Үүнээс гадна төв банкны бие даасан, хараат бус байдалтай холбоотой, төсвийн шинжтэй арга хэмжээнүүдийн талаар асуудал хөндөгдсөн. Цар тахлын эсрэг хуулиар Монголбанкийг ипотекийн хөтөлбөрөө үргэлжлүүл гээд заачихсан. ОУВС-ийн хувьд ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар хэрэгжүүлэх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Гэсэн хэдий ч Засгийн газрын аль яам, агентлаг ипотекийн хөтөлбөрийг хариуцах вэ гэдэг нь одоогоор тодорхойгүй байгаа учраас Төв банкны зүгээс Ковидын эсрэг хуулийн хүрээнд ипотекийг үргэлжлүүлж байгаа. Төрөөс Мөнгөний бодлогын талаар баримтлах Үндсэн чиглэлийн төсөлд ипотекийн хөтөлбөрийг 2023 он гэхэд Засгийн газарт шилжүүлнэ, 2022 онд бэлтгэл ажлыг хангана гэж зааж өгсөн. Тэгэхээр 2023 он гэхэд энэ асуудлыг Засгийн газарт шилжүүлэх учраас цаашдаа энэ талын шүүмжлэл гарахгүй байх.

Ипотекийн хөтөлбөрийн хүрээнд энэ онд 900 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтээр 12400 өрх орон сууцтай болоод байна. Энэ нь Монголбанк ипотекийн хөтөлбөр хэрэгжүүлснээс хойших түүхэн дээд тоо болж байгаа. Энэ хөтөлбөр Засгийн газарт шилжих хүртлээ гэнэт зогсож болохгүй.

Түүнчлэн Ковидын дараа эдийн засаг хэвийн нөхцөл рүүгээ шилжинэ. Энэ үед банкууд эдийн засагтаа хэрэгтэй байгаа санхүүжилтийг хэвийн үргэлжлүүлэх боломжтой юу гэдгийг анхааруулж байгаа. Энэ утгаараа бид банкуудын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлж байгаа. Олон нийтийн хөрөнгийг татан төвлөрүүлж байгаа асуудалд маш анхааралтай байх ёстой учраас энэ ажлыг хойшлуулах хэрэгтэй гэх зэрэг зөвлөмжүүд дурдагдсан. Гэхдээ хууль батлагдсан, дагаж мөрдөх хуулиндаа 2022 оны 7 дугаар сарын 1-ний дотор томоохон банкууд хувьцаагаа олон нийтэд санал болгосон байх ёстой гэж заасан. Бидний хувьд банкны салбарын шинэчлэл амжилттай хэрэгжинэ гэж харж байна. Тийм учраас Монголбанк хуулийг хэрэгжүүлж ажиллана.

Ийгл ТВ: Банкны дүрмийн санг 100 тэрбум төгрөгт хүргэх талаар Монголбанк тушаал гаргасан. Өнөөдрийг хүртэл хэчнээн банк дүрмийн сангийн шаардлагыг биелүүлээд байна вэ?

Банкны дүрмийн санг 2021 он хүртэл үе шаттайгаар 100 тэрбум төгрөгт хүргэх тушаалыг Монголбанкны Ерөнхийлөгч 2017 онд гаргаж байсан. Өнөөдрийн байдлаар 5 арилжааны банк хараахан 100 тэрбум төгрөгт хүргээгүй байна. Үүн дээр Монголбанкны зүгээс анхааруулга хүргүүлсэн. Хэрэв 2021 оны 12 дугаар сарын 31-ний дотор 100 тэрбум төгрөгт хүргэхгүй бол хуулийн дагуу үе шаттай арга хэмжээ авна.

lkon.mn: Банкны хуулийн дагуу жижиг банкууд хувьцааны төвлөрлөө бууруулах ёстой. Богд банк түрүүлж IPO хийж, энэ үүргээ биелүүллээ. Бусад жижиг банкуудын хувьд хувьцааны төвлөрлөө бууруулах ажил хэр явцтай байна вэ?

Богд банк хөрөнгийн биржид бүртгүүлээд нээлттэй ХК болж байна. Бусад жижиг банкуудын хувьд бүгд хуулийн шаардлагын дагуу хаалттай ХК статустай болчихсон байгаа. Томоохон банкууд харин заавал нээлттэй хувьцаат компани болох ёстой. Тэгэхээр IPO-нууд ирэх онд гарна.

Gogo.mn: Засгийн газрын зүгээс ирэх онд ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг 20 хувь болгоно гэж мэдэгдсэн. Энэ шийдвэр үнэхээр хэрэгжих үү? Бэлтгэл ажлууд хангагдсан уу?

Хэрэв ипотекийн зээлийн урьдчилгааг 20 хувь болговол дараа нь 20 жилийн хугацаанд сар бүр төлөх дүн нь өсөхөөр байгаа. Тэгэхээр уг нь 30 хувь хэвээрээ байгаад сар бүр төлөх мөнгөн дээрээ ачаалал бага авах нь зүйтэй болов уу. Өнөөдөр ипотекийн зээлтэй

иргэдийн сард төлж байгаа мөнгөн дүн 480 мянган төгрөг байгаа. Хэрвээ 30 хувиа 20 хувь болговол тэрхүү 480 мянган төгрөг өснө. Энэ утгаараа ачаалал нэмэгдэх хэдий ч БХБЯ-ны зүгээс 20 хувийн урьдчилгааг төлөөд, орон сууцны ипотекут хамрагдах боломжтой гэж үзэж байгаа. Ингэхдээ зөрүү 10 хувийг Зээлийн батлан даалтын санд хамруулах, эсвэл дараагийн зээлийн төлбөрүүдэд нь шингээх үү гэдэг дээр шийдэл хайж байгаа. Ер нь бол зөрүү 10 хувь дээр нь ямар нэгэн байдлаар баталгаа гаргах ч юм уу, тийм байгууллагууд орж ирж байж л ажиллана. Гэхдээ одоогийн байдлаар энэ шийдвэр дээр яг хэзээнээс, хэрхэн хэрэгжиж эхлэх вэ гэдэг тодорхой шийдвэр гараагүй байгаа.

МҮОНТ: Инфляц 10 хувьд хүрсэн байгаа ч төв банк бодлогын хүүгээ хэвээр үлдээж байна. Хэдийгээр инфляцад нийлүүлэлтийн хүчин зүйл голлон нөлөөлж байгаа ч цаашдаа инфляцыг хязгаарлах ямар боломж байна вэ? Та бүхэн энэ талаар Засгийн газарт ямар чиглэл, зөвлөмж хүргүүлж байна вэ?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.БАЯРДАВАА:

Инфляц төв банкны зорилтоос давсан байгаа нь санаа зовоож байгаа асуудал мөн. Гол нь эдийн засгийн сэргэлтийн явцыг удаашруулахгүй байх, хөдөлмөрийн зах зээлийг аль болох богино хугацаанд сэргээх, уналттай байгаа өрхийн хэрэглээг дэмжих гэсэн агуулгаар бодлогын шийдвэрүүдийг гаргаж байна. Бид эдийн засгийн сэргэлтийг дэмжсэн мөнгөний бодлогыг аль болох удаан үргэлжлүүлэхийг зорьж байгаа.


Бодлогын хүүг өсгөхгүй байгаа нэг шалтгаан нь инфляцад эрэлтийн дарамт харьцангуй бага, нийлүүлэлтийн шалтгаантай нөлөөллүүд өндөр байна. Инфляц харьцангуй удаан хугацаагаар өндөр түвшинд үргэлжлэх нь төв банкны хувьд санаа зовоох асуудал болдог. Ийм инфляцыг үүсгэдэг гол шалтгаан нь эдийн засгийн хэт халалт, эрэлт, худалдан авах чадварт буй өсөлтүүд байдаг. Тэгэхээр өнөөдрийн эдийн засгийн нөхцөлийг харвал энд хэт халалтын ямар ч шинж тэмдэг байхгүй. Ойрын 2-3 улиралдаа хэт халалт үүсэх эрсдэл ч харагдахгүй байгаа. Харин ч бидний хувьд ДНБ-ий сөрөг зөрүүг буурлахаар зорьж байна. Нөгөө талаар, нийлүүлэлтийн доголдлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай. Төв банк репо санхүүжилтийн хэмжээг 250 тэрбум төгрөгөөр баталсан. Энэ удаагийн онцлог нь худалдааны салбарт очих санхүүжилтийг илүү нарийвчилж өгсөн. Өөрөөр хэлбэл, худалдааны салбарын хувьд хүнсний гол нэрийн болон стратегийн бараа, бүтээгдэхүүнийхээ нөөцийг бүрдүүлэх чиглэлээр арилжааны банкнаас энэ санхүүжилтийг авах эрхтэй. Энэ нь нийлүүлэлтийн шинжтэй инфляцыг бууруулах чиглэлээр төв банкнаас авч буй нэг төрлийн арга хэмжээ юм.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Бодит ДНБ-ий өсөлт 2021 оны 3 дугаар улиралд **3.6%**-иар өсөв.



Улирлын ДНБ-ий өсөлт




Өсөлтөд үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФЛЯЦ

Бодлогын хүү түүхэн доод түвшин **6 хувь** хэвээр байна.



Эх сурвалж: Монголбанк

ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ



Мах, махан бүтээгдэхүүн

23.3%

УЛААНБААТАР ХОТ



Сүү, сүүн бүтээгдэхүүн

15.9%

2021 оны 10 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд инфляц **9.7%**-тай гарав



Төрөл бүрийн өөрчлөлт

15.9%



Талх, гурил, будаа

9.5%



Хүнсний ногоо

43.3%



Сахар, жимсний чанамал, чихэр, шоколад


6.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


3

M2 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

M2 мөнгөний нийлүүлэлт 2021 оны 10 дугаар сард **26.8** их наяд ₮ хүрч, өмнөх оны мөн үеэс **19.0%**-иар өсөв.



M2-ийн өсөлт байршуулалт талаас




M2-ийн өсөлт эх үүсвэр талаас




Эх сурвалж: Монголбанк

Банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **16.6%-иар өсч 19.9 их наяд төгрөгт** хүрэв.




2021 оны 10 дугаар сарын байдлаар чанаргүй зээл **9.9%-тай** байна.



Зээлийн жилийн өсөлт, салбарын ангиллаар




Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү
(*хөнгөлөлттэй зээл оруулснаар)




Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийн динамик, сая ам.доллар




МУ-ын төлбөрийн тэнцэл 2021 оны 3-р улирлын байдлаар **580.3 сая ам.долларын алдагдалтай** гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц



Санхүүгийн дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанк

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан шинэ Үндсэн хуулиар Төрийн сүлд, далбааг шинэчлэн, улсын нэрийг өөрчилжээ. Иймд мөнгөн тэмдэгтийг шинэчлэх шаардлага зүй ёсоор урган гарсан юм. Тиймээс 1993 онд 1, 5, 10, 20, 50, 100, 500, 1000-н төгрөг, 1994 онд 5000-н төгрөг, 1995 онд 10000-н төгрөг, 2006 онд 20000-н төгрөгийн дэвсгэртийг тус тус хэвлэж гүйлгээнд гаргажээ. 5, 10, 20, 50, 100-н төгрөгийн дэвсгэрт, 500, 1000-н төгрөг, 5000, 10000-н төгрөгийн дэвсгэрт адил зураг чимэглэл, бичвэртэй бөгөөд нэрлэсэн үнэ, өнгөөрөө ялгагдана. Шинэ мөнгөн тэмдэгт нь усан хээ, ялтсан утас, бичил бичвэр, солигддог зураг зэрэг олон төрлийн нууцлалтай. Серийн дугаар нь хоёр үсэг, долоон оронтой тоотой.





Зөвшөөрөл бүхий төлбөрийн хэрэгсэл-Цахим мөнгө

№	Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	Зөвшөөрлийн нэр	Зөвшөөрөл олгосон өдөр
1	Мобифинанс ББСБ ХХК Оноосон нэр – Монпэй(Монрау)	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2018.09.27
2	Супер ап хэтэвч ХХК Оноосон нэр - Супер ап хэтэвч	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2020.05.20
3	Ардкредит ББСБ ХК Оноосон нэр - Ард Апп	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2020.05.20
4	Эм Пи Эс Си ББСБ ХХК Оноосон нэр - Төгс цахим хэтэвч	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2020.11.04
5	Инвескор хэтэвч ББСБ ХХК Оноосон нэр - Покет(Pocket)	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2020.12.08
6	Хай пэймэнт солюшнс ХХК	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2021.03.10
7	Нэт капитал финанс корпораци ББСБ ХХК	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2021.08.30



ЦАХИМ МӨНГӨ НЬ САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ

Монголбанкнаас 2021 онд төлбөрийн системийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байгаа билээ. Энэ талаар тодруулахаар Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анартай ярилцсныг үүгээр толилуулж байна.

ЮУНЫ ӨМНӨ ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР МОНГОЛБАНКНААС ЯМАР ЗОХИЦУУЛАЛТУУДЫГ ХИЙЖ БАЙГАА ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ ҮҮ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд заасны дагуу санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Сэндбоксын орчинг бий болгон ажиллаж байна. Энэ нь төлбөрийн болон санхүүгийн үйлчилгээнд дэвшилтэд технологийг нэвтрүүлэхийг зорьж буй финтек байгууллагыг дэмжих зорилготой эрх зүйн орчин юм. Өнгөрсөн хугацаанд Сэндбоксын хүрээнд Монголбанкнаас зөвшөөрөлтэй цахим мөнгөөр үнэт цаасыг нийтэд санал болгосон нь төлбөрийн үйлчилгээнээс гадна санхүүгийн үйлчилгээг цахим мөнгөөр авах боломжтой гэдгийн нэг жишээ боллоо. Монголбанк Инновацийн оффис байгуулсан. Энэ нь дэвшилтэд технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нийтэд санал болгох финтек байгууллагууд хүрэлцэн ирж, эрхзүйн орчин болон дэд бүтцийн шийдлийн талаар санал солилцож зөвлөлдөх бүрэн боломжийг бий болгосон.

ЦАХИМ МӨНГӨӨР ҮНЭТ ЦААС ХУДАЛДАЖ АВНА ГЭДЭГ НЬ ИХ СОНИРХОЛ ТАТАЖ БАЙНА. ОДОО БОЛ ТӨЛБӨР ТООЦООНЫ ДИЙЛЭНХ НЬ

ЦАХИМААР ХИЙГДЭЖ БАЙНА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХДОО БИД ЯМАР Ч АСУУДАЛГҮЙ ДАНСНААСАА МӨНГӨӨ ШИЛЖҮҮЛЭЭД АРИЛЖААНД ОРОЛЦОЖ БОЛНО ШҮҮ ДЭЭ. ГЭТЭЛ ЦАХИМ МӨНГӨӨР ОРОЛЦОНООР ЯМАР ДАВУУ ТАЛТАЙ ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА ВЭ?

Үнэт цаас ба мөнгө гэсэн 2 талт төлбөр тооцоон дээр суурилж явагддаг уламжлалт хэлбэрийг халж, цахим мөнгөөр үнэт цаас худалдан авах, брокерын данс, бонд захиалгын данс зэргийг цахим мөнгөний аппликэйшнээр дамжуулан шуурхай, түргэн гүйцэтгэх боломжийг цахим мөнгө олгож байгаа нь онцлог юм. Мөн, цахим мөнгөний үйлчилгээг шинэ зах зээлд нэвтрүүлснээр санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнтэй холбоотой төлбөр тооцоог түргэн шуурхай, саадгүй гүйцэтгэх, үр дүнгийн тооцооллыг хийх цаг хугацааг хэмнэх, үйл ажиллагааг хялбаршуулах зэрэг давуу талууд бий болж байна. Цахим мөнгө нь банкна дахь мөнгөн хөрөнгөөр баталгаажсан байдаг тул үр ашигтай, ашиглахад хялбар, найдвартай гэсэн үг. Цахим мөнгөний гүйлгээ нь Монголбанкны ажиллуулж буй бага дүнтэй төлбөрийн АСН+ системээр дамжиж 7/24 горимоор тасралтгүй хийгддэг.

ТЭГЭХЭЭР ЦАХИМ МӨНГӨ НЬ ТӨЛБӨР ТООЦООНЫ ШИНЭ АРГА ХЭЛБЭР ЮМ БАЙНА ГЭЖ ОЙЛГОГДОЖ БАЙНА.

Тийм ээ. Таны зөв. Технологийн өндөр хурдтай 21-р зуунд төлбөр тооцоо хийх нь зөвхөн өр төлбөрийг барагдуулах гэхээс илүүтэйгээр та бидний цахим харилцааны бас нэгэн шинэ соёл бий болж байна. Өөрөөр хэлбэл, 2 хүн нэг ижил төлбөрийн хэрэгсэл ашигладаг бол гуравдагч этгээд түүнд заавал нэгддэг. Энэ нь төлбөр тооцоог цаасан мөнгөөр хийхээс илүү хурдан, найдвартай бөгөөд хүн хоорондын харилцааг сонирхолтой болгож байдаг шинэлэг арга юм. Цаашид финтек компаниуд нь санхүүгийн үйлчилгээний зардлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд санаачлагатай ажиллаж, хууль тогтоомжийг мөрдөж, улс орны эдийн засгийн хөгжил, санхүүгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

ЗА ОЙЛГОЛОО. ОДООГИЙН БАЙДЛААР ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХТЭЙ 7 ФИНТЕК КОМПАНИ БАЙНА. ҮҮНЭЭС ЦААШ ХЭР ХЭМЖЭЭНД ӨРГӨЖИХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаас хойш банкнаас бусад этгээд төлбөрийн үйлчилгээ эрхлэх боломжтой болсноор цахим мөнгө гаргагч нарын тоо эрчимтэй нэмэгдэж байна. Энэ нь технологийн дэвшилд суурилсан шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, зардлыг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа. Цаашид цахим мөнгөний үйлчилгээ зах зээлийнхээ зарчмаар, хууль тогтоомжийн хүрээнд улам хөгжих нь цаг хугацаа, орон зайнаас үл хамаарах хялбар, шуурхай үйлчилгээг нийтэд хүргэх шинэ гарц болно гэж үзэж байна.

ХАРИЛЦАГЧ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХООРОНДЫН ХАРИЛЦААГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХЭРХЭН ЗОХИЦУУЛСАН БАЙДАГ ВЭ?

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд зааснаар цахим мөнгө гаргагч нь төлбөрийн үйлчилгээ

үзүүлэгч тул төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, харилцагчтай харилцах харилцаа зэргийг хуулинд тусгасан байдаг. Түүнчлэн хуулийг дагалдан гарсан журам, заавар, дүрэмд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон харилцагч хоорондын харилцааг зохицуулсан нарийн зохицуулалтууд бий. Тодруулбал, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 26 дугаар зүйл, Монголбанкны холбогдох журамд хэрэглэгчийг хамгаалахтай холбоотой заалтаас гадна төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч хооронд байгуулах гэрээнд зайлшгүй тусгасан байх шаардлагатай зүйлсийг тодорхой заасан байдаг. Тухайлбал, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчтэй гэрээ байгуулахаас өмнө тухайн хэрэглэгчид өөрийн үзүүлэх гэж буй үйлчилгээний талаар болон аливаа хураамж шимтгэл, ханшийн тухай мэдээллийг өгөх, гэрээнд оролцогч талуудын эрх, үүрэг, маргаан гарсан үед авах арга хэмжээ гэх мэт мэдээллийг гэрээнд тусгахыг шаарддаг.

МОНГОЛБАНКНААС ЦАХИМ МӨНГӨ ГАРГАХААР СУДАЛЖ БАЙГАА ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ ҮҮ. ХЭРЭГЖИХ ТОХИОЛДОЛД ХЭРЭГЛЭЭНД ЯАЖ АШИГЛАГДАХ ВЭ?

Төв банкнаас цахим мөнгө гаргаж турших шаардлагатай эсэх, ямар хэлбэр, зориулалттайгаар гаргах талаар судлах чиг үүрэгтэй ажлын хэсгийг Монголбанкнаас байгуулаад ажиллаж байна. Цахим мөнгөний зорилго, хэрэгцээ, ямар технологи дээр суурилж гаргах, нууцлал аюулгүй байдлыг хэрхэн хангах, Төв банк бие дааж гаргах эсхүл хувийн хэвшил болон бусад байгууллагатай хамтрах эсэх, мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдал, хууль эрх зүйн орчин гэх мэт судлах шаардлагатай олон асуудал яригдах учраас хариуцсан салбар бүрийн мэргэжилтнүүдээс бүрдсэн судалгааны баг ажиллах шаардлагатай гэж үзсэн. Дэлхийн олон улс оронд Төв банкны цахим мөнгө гаргах асуудал зөвхөн судалгааны төвшинд явж байгаа. Яг бодит байдал дээр цахим мөнгө гаргасан орон маш цөөхөн байна. Цахим мөнгөн гаргахдаа иргэдийн гар дээрх бэлэн мөнгийг орлосон, нийтээр хэрэглэх, бага дүнтэй төлбөр тооцоонд ашиглагдах цахим мөнгө гаргах

уу эсхүл зөвхөн санхүүгийн байгууллага хооронд хэрэглэх, их дүнтэй төлбөр тооцоонд ашиглах цахим мөнгө гаргах уу гэдэг нь улс орон бүрийн онцлогоос хамаарч янз бүрийн байр суурьтай байна. Санхүүгийн хүртээмж харьцангуй хязгаарлагдмал, төлбөр тооцооны систем сул хөгжсөн, бэлэн мөнгөний хэрэглээ өндөртэй улс орнууд нийтээр хэрэглэх, бэлэн мөнгийг орлох цахим мөнгө гаргахыг судлах хандлага илүү байгаа бол хөгжингүй орнууд болох Сингапур, Канад, Швецарь гэх мэт улсууд зөвхөн санхүүгийн байгууллага хоорондын, их дүнтэй төлбөр тооцоонд ашиглахаар судалж байна. Манай орны хувьд төлбөрийн систем харьцангуй сайн хөгжсөн, ойролцоогоор нийт иргэдийн 93% нь харилцах данстай, мөн гар утас, төлбөрийн картаар хийж буй бэлэн бус төлбөр тооцоо жилээс жилд өсч буй энэ үед Төв банк заавал дахиж нэг төлбөрийн хэрэгсэл гаргаж, нэмэлт зардал үүсгэх шаардлагагүй, харин банк санхүүгийн байгууллага хоорондын төлбөр тооцоонд хэрэглэх цахим мөнгийг гаргах эсэх дээр судалгаа хийнэ. Санхүүгийн байгууллага хооронд ашиглах цахим мөнгө зээлийн эргэн төлөлт, репо хэлцэл, своп, форвард хэлцэл, эсхүл үнэт цаасны гүйлгээ гэх мэт аливаа нөхцөлд гүйлгээ хийх үед ухаалаг гэрээний тусламжтайгаар төв банкны мөнгөөр төлбөр тооцоог саадгүй, эрсдэл багатайгаар гүйцэтгэхэд давуу тал болно гэсэн урьдчилсан дүгнэлт гараад байна.

ҮҮНЭЭС ГАДНА МОНГОЛБАНКНААС ЧИПТЭЙ ₮ БРЭНДИЙН КАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ БОЛСОН. ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУДААС ИРЖ БУЙ СЭТГЭГДЛҮҮДЭЭС ХУВААЛЦААЧ.

₮ карт нь Монгол Улсын дотоодын брэнд төлбөрийн карт гэдэг утгаараа карт гаргагч гадны улсын картын байгууллагад нэмэлт шимтгэл төлөхгүй, зардал хэмнэх давуу талтайгаас гадна картын нууцлал аюулгүй байдал сайжирч, үүнтэй холбоотой үүсдэг маргаан багасна гэж үзэж байна. Энэ үүднээс хамтрагч байгууллагууд төслийг анхнаас нь дэмжиж хамтарч ажилласан. Энэ дашрамд энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэхэд хамтарч ажилласан

бүх байгууллагууд ялангуяа банкууддаа талархал илэрхийлэхийг хүсч байна.

КАРТАА СОЛИХ ХҮСЭЛТЭЙ ИРГЭДЭД БАНК ХЭРХЭН ҮЙЛЧИЛЖ БАЙГАА ВЭ?

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр карт авах иргэдэд зөвхөн чиптэй ₮ картыг зах зээлд нийлүүлэхийг банкуудад үүрэг болгож, соронзон тууз бүхий ₮ картыг зах зээлд гаргахыг хориглосон. Мөн карт гаргагч нар 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн соронзон туузтай картын гүйлгээг зогсоох, чиптэй ₮ карт руу бүрэн шилжсэн байхыг үүрэг болгосон. Соронзон тууз бүхий ₮ картын хэрэглэгчид маань өөрийн картын хугацааг дуустал буюу хамгийн цаад тал нь 2024 оныг хүртэл өөрийн хуучин картыг ашиглах боломжтой ч түүнээс өмнө өөрийн хүсэлтээр чиптэй ₮ картыг харилцдаг банк дээрээ очиж солиулж авах эрх нь нээлттэй. Солиулж авах зардлыг хэрэглэгч өөрөө төлнө. Энэ нь шинээр карт авдагтай яг ижил зарчим үйлчилнэ гэсэн үг. Хэрэглэгч нарт хандаж хэлэхэд та өөрийн соронзон тууз бүхий ₮ картыг чиптэй ₮ картаар аль болох эртхэн солиулснаар өөрийгөө картын залилан луйврын гүйлгээний эрсдэлээс хамгаалахаас гадна картыг зайнаас уншуулж төлбөр тооцоог хурдан шуурхай хийх боломжтой болж байгаа юм шүү.

ЭЦЭСТ НЬ СОНИРХОХОД БАНКУУД НЭГДСЭН QR КОДООР КАРТ УНШИХ БОЛОМЖТОЙ ЮУ? ЭНЭ ТАЛААР СУДАЛЖ ҮЗСЭН ҮҮ?

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдээс санал авч Монгол Улсын төлбөр тооцоонд нийтээр ашиглах QR төлбөр тооцооны мессэжийн бүтцийг бий болгосон. Ингэхдээ олон улсын EMV-ийн QR кодын бүтэц дээр суурилсан. Тиймээс тус мессэжийн бүтцийг энэ оны сүүл, ирэх оны эхээр нийтэд мөрдүүлэхээр төлөвлөж байна.

Сонирхолтой мэдээлэл өгсөнд баярлалаа.

Монголбанк нь төлбөрийн системийг хөгжүүлэх, боловсронгуй болгох хүрээнд банкуудтай хамтран соронзон туузтай ₮ картыг олон улсын жишигт нийцсэн EMV чип технологид амжилттай шилжүүллээ. Ингэснээр соронзон туузтай картын мэдээллийг хуулбарлах, дуураймал картаар гүйлгээ хийх эрсдэл буурч, ₮ картын нууцлал, аюулгүй байдал сайжирч, картыг зайнаас уншуулах боломжтой болохын зэрэгцээ карт эзэмшигч төлбөр тооцоогоо чиптэй картаар гүйцэтгэхэд илүү хялбар, хурдан боллоо.

Иргэн та өөрийн харилцдаг банкаараа дамжуулан авах боломжтой.

- Пин кодгүй
- Гар дамжуулахгүй
- Зайнаас уншуулна

₮ картны албан ёсны хуудас: <https://www.facebook.com/-card-100526595755113/>



Гар дамжуулахгүй

* Пин кодгүй

EMV чиптэй

* EMV ЧИПТЭЙ БОЛЛОО

Д.ГАН-ОЧИР^{1*}Ж.ЭНХБАЯР^{2*}Б.ГЭРЭЛМАА^{3*}

НҮҮРСТӨРӨГЧИЙН ЯЛГАРЛЫГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТЭГ (NET ZERO) БАЙЛГАХ ЗОРИЛТ: МОНГОЛ УЛСАД АНХААРАХ АСУУДЛУУД

1. УДИРТГАЛ

Эрдэмтэд 20-р зууны сүүлээс эхлэн хүлэмжийн хийн нөлөө¹-ний улмаас дэлхийн дулаарал нэмэгдэж байгаа талаар тогтоожээ. Хүлэмжийн хийн сөрөг нөлөөг үүсгэх химийн нэгдэл нь нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂) бөгөөд ой модны хэмжээ буурах, газрын элэгдэл үүсэх, байгалийн хий, нүүрс зэрэг эрдэс бүтээгдэхүүнийг шатаах үед ялгардаг байна. Америкийн Үндэсний агаарын тээвэр ба сансрын нислэгийн алба (NASA)-ны мэдээлснээр аж үйлдвэржилт эхэлснээс хойш хүний үйл ажиллагаа нь нүүрстөрөгчийн давхар ислийн нягтралыг 47 хувиар нэмэгдүүлжээ. Түүнчлэн нүүрстөрөгчийн давхар исэл, метан зэрэг хүлэмжийн хийг ялгаруулж буй хүний үйл ажиллагаа нь дараагийн 50 жилд дэлхийн дулаарлыг нэмэгдүүлэх магадлал 95 хувьтай байна.

Дэлхийн дулаарал нь байгалийн гамшигт үзэгдлийн тохиолдох давтамж, хамрах хүрээг нэмэгдүүлснээр хүн төрөлхтний амьдралд сөргөөр нөлөөлж эхэллээ. Тодруулбал, сүүлийн 30 жилд

байгалийн гамшигт үзэгдлийн хэмжээ 3 дахин нэмэгдэж, 10 жилийн дотор цаг агаарын өөрчлөлтөөс үүдэлтэй даатгалын зардал 8 дахин, даатгалын бус зардал 7 дахин нэмэгджээ. Бохирдол, нүүрстөрөгчийн хэт ялгарлаас үүдэлтэй дэлхийн дулаарал нь үер, хар салхи, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгийн шалтгаан болсноор 2100 онд дэлхийн ДНБ 25 хувиар буурах эрсдэлтэй байна (Working Group on Climate Change and Finance, 2020). Иймд бодлого боловсруулагчид зөвхөн эдийн засгийн өсөлтийг чухалчлахаас илүүтэй хүлэмжийн хийн ялгарал, дэлхийн дулаарлыг бууруулах тогтвортой ногоон өсөлтийг зорьж эхэлсний томоохон илрэл нь Парисын хэлцэл юм.

Парисын хэлцэлд дэлхийн 196 улс нэгдсэн бөгөөд үндсэн зорилт нь 21-р зуунд дэлхийн дулаарлыг 1.5 градусаас хэтрүүлэхгүй түвшинд хадгалах юм. Тус хэлцэл нь дэлхийн тогтвортой өсөлтийг хангах байгаль орчны хамгийн том хэлцэл бөгөөд НҮБ-аас “Зөвхөн цаг агаар, хүрээлэн буй орчны нөхцөл байдлаас гадна дэлхийн хамтын ажиллагааг хангах хүрээнд улс орнууд Парисын хэлцлийг биелүүлэх бүрэн боломжтой. Хэлцлийг зөрчсөнөөр үүсэх ашиг, давуу тал байхгүй. Харин ч өөрийн иргэд, бусад улсууд санхүүгийн зах зээлд дэлхий нийтээр сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм” хэмээн мэдэгдсэн нь улс орнуудын зорилтдоо хүрэх хөшүүргийг бүрдүүлжээ.

Парисын хэлцлийн хүрээнд олон улс орнууд дэлхийн дулаарлын томоохон шалтгаан болж буй нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах, ялгаруулсан болон шингээсэн хэмжээг тэнцвэртэй байлгах (Net

¹ Дэлхий ялгаруулсан эсвэл нарнаас хүлээн авсан дулаанаа хүлэмжийн хийн нөлөөгөөр агаар мандалд бүрэн тархаалгүй буцааж дэлхий рүү цацруулах үйл явцыг ойлгоно.

Энд дурдагдах аливаа санал, дүгнэлт нь олон улсын судалгааны байгууллага, судлаач шинжээчдийн зөвлөмж, улс орнуудын Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээний эмхэтгэл бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

^{1*} Монголбанкны Ерөнхий эдийн засагч, эдийн засгийн шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн Дэд профессор. Цахим шуудан: doojav_ganochir@mongolbank.mn.

^{2*} Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтсийн эдийн засагч. Цахим шуудан: enkhbayar.j@mongolbank.mn.

^{3*} Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн эдийн засагч. Цахим шуудан: gerelmaa.b@mongolbank.mn.

zero)-аар дэд зорилт тавьжээ. Нүүрстөрөгчийн ялгарлыг эх үүсвэрээр ангилбал 70-аас илүү хувийг дулаан, цахилгаан, тээвэр, 94-өөс дээш хувийгнүүрс, газрын тос болон байгалийн хийнээс, 40-өөс дээш хувийг БНХАУ, АНУ зэрэг орнууд бүрдүүлж байна. Хятадын нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээ 2000 оноос хойш эрчимтэй өссөөр 2020 байдлаар нийт бохирдлын 29 хувийг дангаар бий болгож байна.

Нүүрстөрөгчийн ялгарлын томоохон үйлдвэрлэгчид (БНХАУ, Европ, Австрали зэрэг) нүүрсний хэрэглээ, хөрөнгө оруулалт, татварын бодлогоор дамжуулан “Net-zero” зорилтод хүрэхээ илэрхийлжээ. Иймд энэхүү судалгааны нийтлэлээр судалгааны байгууллагуудаас net-zero зорилтыг амжилттай хэрэгжүүлэх талаар өгч буй зөвлөмж, улс орнуудын хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээг багцлан танилцуулахыг зорив.

2. NET-ZERO ЗОРИЛТОТ ХҮРЭХЭД ШААРДАГДАХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ, УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

2.1. Бодлогын арга хэмжээний зөвлөмж

Нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг бууруулж, цаг уурын өөрчлөлтийг бууруулах түүнд дасах зохицоход Засгийн газрын манлайлал нэн чухал бөгөөд Засгийн газраас төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой хуваарилан, хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, “Net-zero” зорилтот хүрэх урт хугацааны стратеги боловсруулснаар бодлогын тодорхой бус байдлыг бууруулж, бусад талуудыг идэвхжүүлэх нөлөөтэй. Өөрөөр хэлбэл, хувийн секторт бизнес эрхлэгчид Засгийн газрын урт хугацааны стратегид нийцүүлэн өөрсдийн шилжилтийн төлөвлөгөөг боловсруулах, тогтвортой, ногоон ирээдүйд чиглэсэн технологи, бизнест хөрөнгийн урсгалыг татах боломж бүрдэх юм.

Зорилтод нэгдсэн улс орнуудын туршлага болон судалгааны байгууллагуудын өгч буй зөвлөмжөөс дүгнэхэд 1) Засгийн газрын бодлогын нийцтэй, тогтвортой байдлыг хангах, 2) сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, 3) ногоон үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн таатай орчин бүрдүүлэх, 4)

бохирдлын төлбөрийг нэмэгдүүлэх, 5) орлогын дахин хуваарилалтыг дэмжих, 6) ойжуулах зэрэг нь “Net zero” зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй байна.

“Net-zero” зорилтын хэрэгжилтийг сайжруулах чиглэлд үйл ажиллагаа эрхэлж буй судалгааны байгууллагуудын зүгээс бодлого боловсруулагчдад дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Засгийн газарт хамаарах бодлогын зөвлөмж²

- *Бохирдлын төлбөрийг нэмэгдүүлэх:* Хүлэмжийн хий ихээр ялгаруулж буй бизнесүүдэд бохирдлын төлбөрийг өндөр ногдуулснаар тэдний шийдвэр гаргалтад байгаль орчны нөлөөг харгалзах хөшүүрэг болгох, “ногоон” бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах нөлөөтэй. Одоогоор 31 улс бохирдлын төлбөр ноогдуулж байгаа бөгөөд энэ нь 2021 оны байдлаар дэлхийн нүүрстөрөгчийн давхар исэлийн бохирдлын 20 орчим хувьд хамаарч байгаа юм³.
- *Орлогын оновчтой дахин хуваарилалт:* УАӨ-тэй холбоотой олон нийтийг хамарсан зохицуулалтаас үүдэх эдийн засгийн шилжилтийн үед төсвийн нэмэлт орлогоос өрхүүдэд орлогыг дахин хуваарилах нь шилжилтийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ.
- *Бодлогын тогтвортой байдлыг хангах:* Бодлогын стратегийг урт хугацаагаар төлөвлөх, хуульчлах, мөн бие даасан шийдвэр гаргах эрх бүхий зөвлөл байгуулах зэргээр бодлогын тууштай байдалд итгэх бизнес эрхлэгчдийн итгэлийг нэмэгдүүлэх, тулгарч болзошгүй тодорхой бус байдлыг бууруулах.
- *“Net Zero roadmap” боловсруулах:* Замын зураг боловсруулснаар Засгийн газар, санхүүгийн салбарын бодлого боловсруулагчид болон хувийн секторын үйл ажиллагааны уялдааг хангах бөгөөд цаашлаад олон улсын хэмжээнд

² Эх сурвалж: Consultative Group on International Economic and Monetary Affairs, Inc

³ Coalition of Finance Ministers for Climate Action

хэлэлцэгдэж буй худалдааны нэмэлт татвар (Carbon border adjustment)-аас сэргийлж, гадаад худалдааны өрсөлдөх чадварыг дэмжих нөлөөтэй. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 140 гаруй улс “Net Zero” зорилтот хүрэх хугацаагаа танилцуулаад байгаагаас Уругвай (2030), Финланд (2035), Австри, Исланд (2040), Герман, Швед (2045) зэрэг улс 2050 оноос зорилтот хүрэхээ мэдэгдсэн бол Хятад, Казакстан, Украин, Сингапур зэрэг улс 2060 он гэхэд нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг түвшинд хүргэхээр байна.

Санхүүгийн салбарт хамаарах бодлогын зөвлөмж⁴

- *Зохистой бодлогын зохицуулалт*: Санхүүгийн байгууллагууд “Net-zero” шилжилтийн төлөвлөгөө боловсруулах, макро болон микро түвшний зохистой бодлогын хэрэгсэл нэвтрүүлэх.
- *Мөнгөний бодлого*: Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтын тооцоо судалгаанд цаг уурын өөрчлөлт, түүний нөлөөллийг хамруулах.

- *Санхүүжилт*: Олон улсын болон дотоодын хөгжлийн банкуудын зүгээс “ногоон” үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн таатай орчин бүрдүүлэх.

2.2. Томоохон нүүрс экспортлогчдын хэрэгжүүлж буй бодлого

“Net zero” зорилтоос үүдэлтэй ногоон эдийн засаг, эрчим хүчний бодлого нь нүүрс үйлдвэрлэлийн салбарт хүчтэй нөлөөлөх нь гарцаагүй юм (Deloitte, 2020). Ялангуяа, Монгол улс нь 2019 оны байдлаар нүүрсний экспортоор дэлхийд 9-т орсон бөгөөд 2020 онд нийт экспортын 28 хувийг нүүрсний экспорт дангаар бүрдүүлж байна. Иймд нүүрсний үйлдвэрлэл, экспортоор дэлхийд тэргүүлдэг орнууд “Net zero” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй бодлого нь бидэнд чухал мэдээлэл өгнө.

Эдгээр улсууд технологи болон татварын бодлогыг хамтран хэрэгжүүлж, дотоодын нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах, эдийн засгаа төрөлжүүлэх чиглэлд ажиллаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Нүүрс экспортлогч орнуудын хэрэгжүүлж буй бодлого

Улс, 2019 он	Хэрэгжүүлж буй бодлого
Австрали Нүүрсний экспорт \$44.4 тэрбум (нүүрсний нийт экспортын 37.5%)	Дотоодын нүүрсний үйлдвэрлэлийг бууруулах зорилт хараахан тавиагүй, гэхдээ нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах технологийн судалгаа шинжилгээнд их хэмжээний хөрөнгө оруулах, усны эрчим хүчний технологийг сайжруулах, “Технологийн хөрөнгө оруулалтын төлөв: Бага хэмжээний нүүрстөрөгч ялгаруулах технологи – 2020 (Technology Investment Roadmap: First Low Emissions Technology Statement – 2020)” бодлогын бичгийг батлах ажлуудыг хийж байна.
Индонез Нүүрсний экспорт \$21.5 тэрбум (нүүрсний нийт экспортын 18.2%)	Нүүрсний салбарыг хийжүүлэх (coal gasification) төслийн хүрээнд технологийг сайжруулах, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулахаар ажиллаж байна.
ОХУ Нүүрсний экспорт \$16 тэрбум (нүүрсний нийт экспортын 13.5%)	Эдийн засгийн хөгжил, уур амьсгалын стратегийн талаар мэдээлэл хомс.
Колумб Нүүрсний экспорт \$5.2 тэрбум (нүүрсний нийт экспортын 4.4%)	Ногоон татвар ногдуулах, эдийн засгийн орлогын эх үүсвэрийг нүүрс олборлолтоос металл олборлолт руу шилжүүлэхээр төлөвлөж байна.

⁴ Эх сурвалж: Grantham Research Institute on Climate Change and the Environment and Centre for Sustainable Finance, University of London

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс Нүүрсний экспорт \$4.8 тэрбум (нүүрсний нийт экспортын 4.1%)	Урт хугацааны үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд 2030 оноос эхлэн нүүрсний хэрэглээг бууруулж, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх тухай тусгасан боловч цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор нүүрстөрөгчийн ялгарал ихтэй салбаруудад хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж эхэлжээ.
БНХАУ Нүүрсний экспорт \$932.8 сая (нүүрсний нийт экспортын 0.8%)	"Net zero" зорилтыг хангахаа мэдэгдсэн боловч эдийн засгийн бодлогоос үүдэн нүүрсний нэмэлт үйлдвэрүүдийг барьж эхэлсэн. Судлаачдын таамаглаж байгаагаар 2030 хүртэл БНХАУ-ын нүүрстөрөгчийн хэмжээ огцом нэмэгдэх юм.

Эх сурвалж: Засгийн газрын мэдэгдэл, бусад эх сурвалж

3. Монгол Улсад хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал

Монгол Улс 2019 оны байдлаар дэлхийн нийт нүүрсний экспортын 2.6 хувь (\$3.1 тэрбум тэнцэх хэмжээний)-ийг бүрдүүлж байгаа бөгөөд цэвэр дүнгээр нүүрстөрөгчийн бохирдол экспортлогч орнуудын жагсаалтад багтаж байна. Тиймээс дэлхий дахинд өрнөж буй "Net-zero" зорилтод хүрэх, тус зорилтын Монголын гадаад худалдаанд үзүүлж болзошгүй сөрөг үр дагаварыг бууруулах стратеги боловсруулан ажиллах нь эдийн засгийн тэргүүлэх салбар болох уул уурхайн салбарын үйл ажиллагаа, гадаад худалдааны өрсөлдөх чадварыг дэмжихэд туслах юм.

Тоон мэдээлэл нь бүртгэгдсэн нийт 116 орноос 25 нь нүүрстөрөгчийн бохирдол экспортлогч оронд тооцогдож байгаа бөгөөд Монгол улс нүүрстөрөгчийн бохирдлын экспорт дотоодын нүүрстөрөгчийн бохирдол = 15.2% харьцаагаар дэлхийд 8-д жагсаж байна. Өөрөөр хэлбэл хөгжсөн орнуудад хэлэлцэгдэж буй нүүрстөрөгчийн бохирдолтой холбогдох нэмэлт тарифын арга хэмжээ болох "Carbon border adjustment" биеллээ олбол Монгол Улс нүүрсний экспортын хувьд өрсөлдөх чадвар сулрах эрсдэлтэй байна.

Тиймээс бусад улс орнуудын туршлага, судалгааны байгууллагуудын зөвлөмжид үндэслэн Монгол Улс дараах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой байна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт ногоон өсөлт, түүнд чиглэсэн арга хэмжээний талаар тусгах
- Бизнес эрхлэгчдийг өөрсдийн ногоон шилжилтийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх

- Нүүрстөрөгчийн давхар ислийн бохирдлын хэмжээг цэвэр дүнгээр тооцож, хэтийн төлөвийг тооцох нэгж байгуулж, чиг үүргийг тодорхой болгох
- Бодлогын шинжилгээнд байгаль орчны нөлөөлөл, түүнээс үүсэж болзошгүй эрсдэлийн шинжилгээг нэвтрүүлэх, "Carbon border adjustment" арга хэмжээний зардлыг тооцох
- Тээврийн хэрэгслийн татварыг бохирдлын хэмжээгээр ялгаатай тогтоох, нүүрстөрөгч ялгаруулахгүй, цахилгаан тээврийн хэрэгслүүдэд хөнгөлөлт үзүүлэх
- Сэргээгдэх эрчим хүчний технологи, инноваци, судалгаа, шинжилгээнд хөрөнгө оруулах, төлөвлөгөө боловсруулах
- Барилга, байгууламжид бохирдол, нүүрстөрөгч ялгарлын тухай стандартыг нэвтрүүлэх, одоо мөрдөгдөж буй стандартыг сайжруулах
- Санхүүгийн зохицуулагч болон зуучлалын байгууллагууд хамтран ногоон санхүүжилтийн суваг нэвтрүүлэх (БОНХ – байгаль орчин нийгмийн хариуцлагын үнэлгээ мөрдүүлэх)
- Татвар, татаас болон тарифын бусад бодлого: Цахилгааны эх үүсвэрээс хамааран үнийн шал тогтоох. Гэхдээ энэ тохиолдолд сэргээгдэх эрчим хүчний станцууд хангалттай буюу үр ашигтай өрсөлдөөн үүсэх нөхцөл бүрдсэн байх шаардлагатай.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ



Төрийн долоон эрдэнийн нэг бөгөөд Монголчууд норов эрдэнэ, зэндмэнэ хэмээн нэрлэх нь бий. Бурхны шашинд чандмань эрдэнэ нь гэгээрэлд хүрэх сэтгэл, бурхны сургаал номлолыг бэлгэддэг.

Найман талтай найман их ид шидтэй энэхүү эрдэнэ нь халуунд сэрүүцүүлэх, хүйтэнд дулаацуулах шидийг агуулсан аж. Эл эрдэнэ байгаа газарт өвчин зовлон тохиолдохгүй хүссэн бүхэн биелэгдэх учиртай.


Эрт цагт Энэтхэгийн их хаан аптан хүрдэт Загавардин долоон эрдэнэтэй байсан гэх домогтой.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭХ goAML ПРОГРАМЫГ НЭВТРҮҮЛЭЭ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх, улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг ахиулах шаардлага бий. Иймд

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-наас Санхүүгийн мэдээллийн албадад тусгайлан зориулж боловсруулсан goAML програмыг улс орнууд ашиглаж эхэлж байна. Өнөөдрийн байдлаар

goAML програмыг Нидерланд, Мексик, Шинэ Зеланд, Ирланд, Люксембург, Индонези, Балба зэрэг дэлхийн 50 гаруй улсын Санхүүгийн мэдээллийн албадууд ашиглаж байна.



Энэхүү програм нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл цуглуулах, цогц дүн шинжилгээ хийх, төрөл бүрийн статистик гаргах, хууль сахиулах байгууллагад шилжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай боловсруулах зориулалттай. Түүнчлэн, мэдээлэх үүрэгтэй этгээдийн тайлагнах үйл

ажиллагааны чанарыг сайжруулж мөн Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилготой юм. goAML програм нь мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан хуулийн хүрээнд тайлан, мэдээг тайлагнах "гадаад" веб портал болон Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын дүн

шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, статистик үзүүлэх "дотоод" буюу "клиент" програм гэх хоёр хэсгээс бүрддэг гэдгээрээ онцлог юм. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн бүртгэлээс эхлээд хуулийн хүрээнд мэдээлэх тайлан, мэдээлэл, нэмэлт болон хавсралт мэдээг нэг дор хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийх процессуудыг бүрэн нэгтгэсэн цогц систем юм.

EN | MN



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС ТАЙЛАН ХҮЛЭЭН АВАХ ПОРТАЛ

НЭВТРЭХ>>

Бүртгүүлэх

Системд нэвтрэхийн тулд та эхлээд мэдээлэх үүрэгтэй этгээдээр "Байгууллага бүртгүүлэх" цэсийг ашиглан бүртгүүлэх шаардлагатай. Бүртгүүлсний дараа хэрэглэгчийн нэр болон нууц үгээ ашиглан системд нэвтэрнэ үү.

Бүртгүүлэх

Гарын авлага

Системд нэвтрэхээс өмнө goAML WEB гарын авлагатай танилцана уу

Гарын авлага

Холбоо барих

Бага тойруу-3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс
Утас: 976-11-326161, 976-11-326803
Факс: 976-11-311471
E-mail: fiu@mongolbank.mn
Веб: <https://fiu.mongolbank.mn/>

И-мэйл

Мөн goAML програм нь мэдээлэл цуглуулах болон солилцох техник, технологийн дэвшилтэт орчинг бий болгож улмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг түргэн шуурхай, хялбар болгох, оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор нэвтрүүлжээ.

Тус програмыг нэвтрүүлснээр мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нэгдсэн мэдээллийн санд илүү нарийвчилсан мэдээлэл оруулах, Санхүүгийн мэдээллийн албаны шинжээчид сэжигтэй гүйлгээний тайланд илүү цогц дүн шинжилгээ хийх, мөнгөн гүйлгээний зураглал үүсгэх, кэйс бүрээр бүх мэдээллийг нэгтгэн харах, нэмэлт

мэдээлэл цуглуулах, удирдах, дүн шинжилгээ хийх, баримт бичиг шилжүүлэх, ажлын урсгалыг сайжруулах, статистикийн хэрэгцээг хангах цогц нөхцөл бүрдэж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах юм.



Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн 4.1-д заасан этгээд буюу миний дээр дурдсан мэдээлэх үүрэгтэй этгээдүүд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг тайлагнана. Мөн дээрх этгээдүүд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээр хийсэн хөрөнгө, гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг мэдээлэх үүргийг хүлээхээс гадна гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол сэжигтэй гүйлгээний тайлан дээр нь нэмэлт мэдээлэл,

хавсралтуудыг goAML програмаар дамжуулан мэдээлэх боломжтой.

Өнөөдрийн байдлаар goAML програмын туршилтыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.1 дэх хэсэгт заасан банкуудтай хийж байгаа бөгөөд бүрэн ашиглах бэлтгэл хангагдаж байна. Цаашид банк бус санхүүгийн байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчид, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, үл

хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид зэрэг хуульд заасан бусад мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийг дараагийн шатанд goAML програмын туршилтад хамруулах зорилготой ажиллаж байна. Туршилт дуусч goAML програм бүрэн нэвтэрсэн үед мэдээлэх үүрэгтэй бүх этгээд ашиглах боломжтой.

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны хувьд 2020 оны 2 дугаар сараас goAML програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, програмын мэдээлэл хүлээн авах схем болон холбогдох талбаруудыг Монгол Улсын хууль эрх зүйн орчин, мэдээллийн төрөлд нийцүүлэн тохируулах, веб порталын интерфейсийг Монгол хэл рүү орчуулах, схемийн танилцуулга, заавар болон дагалдах бусад баримт бичгийг боловсруулан бэлэн болгоод байна. Арилжааны банкуудын хувьд 2020 оны 6 дүгээр сараас эхлэн Санхүүгийн мэдээллийн албатай хамтран goAML зориулсан XML файл бэлтгэх, ажилтнуудаа сургах бүх шаардлагатай туршилтыг дуусгаж 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс бодит горимд шилжиж урьдчилсан нэвтрүүлэлт (soft launch) хийж туршилтыг үргэлжлүүлж байна. 2022 онд goAML програмыг бүх мэдээлэх үүрэгтэй этгээдүүд бүрэн ашиглаж эхлэнэ гэж хүлээж байгаа.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ ХАНГАГДАХАД НИЙГМИЙН УХАМСАР, СОЁЛЫН ХАНДЛАГА ИХЭЭХЭН ХАМААТАЙ



М.БОЛДОО ToC Холбооны Гүйцэтгэх Захирлын үүрэг гүйцэтгэгч

Монгол Улсын Засгийн газраас уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч, энэ асуудлын хүрээнд нэгдмэл байх шаардлага тавигдаж байна шүү дээ. Танай холбооны хувьд үйл ажиллагааны зорилго яг л үүн тийш чиглэсэн учраас төрөөс хэрэгжүүлэх энэхүү бодлогын дор улам өргөжих боломж бий болж байна гэж харж байна.

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, нийгэмд гарч буй сөрөг үзэгдлүүдийг бууруулахад санхүүгийн салбараас хувь нэмрээ оруулах зорилгоор Монгол Улсад 2013 оноос эхлээд Монголын банкуудын холбоо тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөрийг анх хэрэгжүүлэхэд IFC, FMO зэрэг олон улсын байгууллагууд маш ойр дотно тусламж

үзүүлсэн. Одоогоор тогтвортой санхүүжилтийн 8 зарчим, мөн түүнчлэн байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлагыг санхүүгийн байгууллагуудад нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. Тогтвортой санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэх ногоон зээл олгохын тулд банк санхүүгийн байгууллагууд эхлээд өөрсдийнхөө дотоод соёлыг өөрчлөх, хандлагаа өөрчлөх шаардлагатай байгаа юм. Мөн банк санхүүгийн байгууллагуудын дотоод чадавх, зохион байгуулалт, бүтэц, энэ бүгдийг ногоон зээл, тогтвортой санхүүжилтэд олгоход бэлдэх шаардлага гарсан. Тийм учраас энэ жил банкуудад холбогдох сургалтуудыг хийж эхэлсэн. Дээрээс нь банкууд байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээгээ өөрсдөө хийж эхэлсэн. Тэр үнэлгээг нь холбооноос баталгаажуулдаг

болсон. Өнөөдрийн хувьд жишээлбэл олон улсын Ази Номхон далайн бүс нутагт тогтвортой санхүүжилтийн бэлтгэл ажлын хувьд Монгол Улс, тэр дундаа Монголын санхүүгийн салбар ахисан түвшинд байна гэж үнэлэгдэж байгаа нь 2013 оноос буюу 8 жилийн өмнөөс эхэлсэн ажлын үр дүнгийн үзүүлэлт гэж дүгнэж байна.

Зүгээр ч нэг ногоон зээл өгөхөд оршоогүй, үүний цаад нөхцөл байдал, гарах үр дүнг тооцоолохын тулд суралцах, бэлтгэгдэх шаардлага нэлээд байжээ дээ?

Тэгэлгүй яах вэ. Өөрөөр хэлбэл, саалиа бэлдэхээр саваа бэлд гэж үг байдаг шиг өөрсдийнхөө чадавхыг эхлээд сайжруулах шаардлагатай болсон. Түүнээс биш чадавхгүй байж ногоон зээл олгох, тогтвортой зээл олгох тухай

ярих боломжгүй. Өөрийн чадавхыг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр ногоон активууд, ногоон зээлийг бий болгох шаардлагатай болсон. Ногоон зээл гэж юу вэ, тогтвортой зээл гэж юу юм бэ гэдэг ангилал шалгуур үзүүлэлт нь огт байхгүй байгаа. Тэгэхээр энэ шалгуур үзүүлэлт, ангиллуудыг бий болгох зорилгоор ногоон таксономийг боловсруулж санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2 жилийн өмнө батлуулсан. Ногоон таксономийг боловсруулахад бас л олон улсын байгууллагууд тусламж үзүүлсэн. Тухайлбал, IFC, UNEP гэх мэт байгууллагууд тусламж үзүүлсэн. Ногоон таксономийг үндэслээд банкууд ногоон зээлийг хүрэн зээлээс ялгах анхны алхам хийгдсэн.

Дараагийн алхам нь SDG Finance Taxonomy гэдэг баримт бичиг дээр UNDP -тэй хамтраад ТОС холбоо ажиллаж байгаа нь банкууд болон хөрөнгийн бирж, төсвөөс олгож байгаа зээл, хөрөнгө оруулалтуудыг ТТЗ-уудад нийцэж байгаа үгүй ялгах зорилгоор ийм ангилал бий болгож байгаа юм. Салбар болгоноор, бүтээгдэхүүнээр, шалгуур үзүүлэлтүүдийг экспертүүдийн тусламжтайгаар бий болгож байна. Шууд ногоон зээл олгох боломжгүй. Маш их бэлтгэл ажил хэрэгтэй байдаг. Энэ ажлуудыг ТоС холбооноос хийж байна. Үүнд зөвхөн ТоС холбоо биш төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагууд иргэний нийгэм, хэвлэл

мэдээлэл, нийгэм тэр чигээрээ холбоотой уялдаа холбоотой хамтран ажиллаж байж л энэ ажил жигд урагшилна.

Засгийн газраас танилцуулсан үндэсний санхүүжилтийн стратегийг хэрэгжүүлэхэд ТОС холбооноос хэрхэн оролцож хамтарч ажиллах бол?

Үндэсний санхүүжилтийн стратеги боловсруулах ажил бол маш чухал ач холбогдолтой ажил гэж үзэж байна. Яагаад гэвэл энд манлайлал хэрэгтэй. Манлайлыг төр, хувийн хэвшлийнхэн хамтдаа үзүүлэх хэрэгтэй. Энэ асуудлын мөн чанарыг ойлгохгүйгээр улс орныг удирдаж, хувийн бизнес хөгжүүлнэ гэдэг бол маш богино хугацааны төлөвлөгөө болон дунд, урт хугацаандаа нэлээн том бэрхшээлтэй учирна. Тийм учраас санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог бий болгоно гэдэг нь манлайллыг бий болгох, дээрээс нь төр, хувийн хэвшлийн уялдааг бий болгоход чухал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ гэж бодож байна. Тэр дотроо хувийн хэвшлээс нэгэнт ТоС холбоогоор дамжаад Монголын арилжааны банкнууд, банк бус санхүүгийн байгууллагууд тогтвортой санхүүжилтийг бий болгох санаачилгаа санхүүжилтийн нэгдсэн тогтолцоонд холбоод, уялдуулаад явахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа илүү хүчтэй болно гэж бодож байна. Энэ хамтын ажиллагааг удирдах механизм байх ёстой. Нэгдсэн

санхүүжилтийн тогтолцоогоор дамжаад нэгдсэн удирдлага нь уялдаа холбоотой ажиллах байх гэж найдаж байна.

Монголын ногоон санхүүгийн корпорац байгуулах санаачлага гарсан. Тэгэхээр үйл ажиллагааны цар хүрээний хувьд нэлээд өргөжихөөр байна уу?

Монголын ногоон санхүүгийн корпорацыг санаачлан үүсгэн байгуулсан байгууллага нь ТоСхолбоо ТББ юм. Ер нь банкууд 8 жилийн тэртээ байгаль орчин нийгэмд сайн сайхан нөлөөлөл үзүүлэхийн тулд бид өрсөлдөх биш хамтран ажиллах хэрэгтэй гэдгээ бүгд хүлээн зөвшөөрцгөөсөн. Тэр санаачилгуудын нэг нь ногоон зээлийн сан байгуулах санаачилга байсан. Ногоон зээлийн сангаар дамжин хөрөнгө татаад ногоон зээлийг илүү хүртээмжтэй олгох бололцоотой болно гэж үзсэний үндсэн дээр Монголын ногоон санхүүгийн корпорацын анх санаа нь гарсан. Энэ санаачилга явсаар Green Climate Fund -аар батлагдаад Монголын талаас Монголын төр, Засгийн газар мөн санхүүгийн байгууллагууд хөрөнгө оруулалт хийж олон улсын төр, хувийн хэвшлийн хамтарсан компани болохоор хүлээгдэж байгаа. Энэ компаниар дамжаад тогтвортой санхүүжилт ногоон санхүүжилт гэдэг нарийн мэдлэг, мэргэшил шаардсан үйл ажиллагааг санхүүжүүлэхэд илүү хурдацтай болох юм.

Дээрээс нь банк, санхүүгийн байгууллага бүр түүнчлэн төрийн байгууллагууд ч гэсэн тус тусдаа тогтвортой хөгжлийн чадавхыг бий болгоход маш их цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардах учраас, Монголын ногоон санхүүгийн корпорац гэдэг дундын байгууллагыг бий болгоод мэдлэг туршлагаа нийлүүлээд санхүүжилтээ хуримтлуулж бий болгоод буцаагаад ногоон санхүүжилтийн сайн сайхны төлөө, нийгмийн сайн сайхны төлөө зарцуулах нь хамгийн ухаалаг, үр ашигтай арга болох юм гэж үзсэний үндсэн дээр энэ төсөл хэрэгжинэ.

Хэрэгжилтийн үр дүн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хувийн хэвшлийнхний үйл ажиллагаан дээр тод илрэх учиртай гэж ойлгож байна. Мөн адил, мэдлэг мэдээллээр хангагдах зайлшгүй шаардлагатай учраас оролцоог нь хангахад яаж анхаарах вэ?

Хувийн компаниудын хувьд бас адилхан, тогтвортой хөгжил, тогтвортой санхүүжилт, ногоон зээл гэдэг талаар мэдэж судлах, ойлгох, ойлгоод барахгүй, амьдралд нэвтрүүлэхийн тулд маш их хугацаа, хөрөнгө мөнгө шаардаж байгаа учир, компаниуд энэ ажлыг тус тусдаа хийх нь маш их зардалтай. Тийм учраас тогтвортой санхүүжилтийн зарчмыг гаргаж ТОС холбооноос 5 салбарт зориулж удирдамж гаргасан. Өөрөөр хэлбэл санхүүгийн байгууллагаар дамжуулж хувийн секторт нөлөөлөх нөлөөллийн



арга хэмжээг 8 жилийн өмнөөс хийж эхэлсэн. 5 салбар гэдэг нь хөдөө аж ахуй, уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, нэхмэлийн салбарт ногоон зээлийг олгох шалгуур үзүүлэлт удирдамжийг гаргасан. Энэ шалгууруудыг банкны байгууллагууд үйл ажиллагаандаа хэрэглээд цаашаа харилцагч болох хувийн компаниудад нөлөөлөх замаар байгаль орчинд ээлтэй, нийгэмд ээлтэй шалгуур үзүүлэлтийг биелүүлэх нөхцөлийг тавих боломжтой болсон. Нөхцөл тавих замаар хувийн секторт нөлөөлөх замаар энэ процессыг хурдасгах зорилготой байна.

Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилтууддаа хүрэх нь чухал шүү дээ. Гэхдээ үүнд хүрэхийн тулд биднээс ямар бэрхшээлийг даван туулах шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хамгийн гол нь энд мөнгө төгрөг гэхээсээ илүү хандлагын

асуудал байгаа. Бичил, жижиг, дунд, том компаниуд нь ашгаас гадна эрхэлж буй үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчиндоо ямар сөрөг эерэг нөлөө үзүүлэх вэ гэдгийг л боддог байх ёстой. Ийм хандлагатай болчих юм бол тогтвортой хөгжлийн зорилтууд биелэхэд маш хурдан, ойрын хугацаанд биелүүлэх боломжтой гэж бодож байна. Жишээлбэл иргэний хувьд хог хаяхаа больчих л юм бол ТХЗ-д нэг алхмаар ч гэсэн ойртоно. Компаниуд бизнесийнхээ үйл ажиллагааг явуулахад тэдний гаргаж байгаа бүтээгдэхүүн үйлчилгээ нь байгаль орчныг бохирдуулдаггүй, хэн нэгэн хүний амьдралыг доройтуулдаггүй байх юм бол мөнгөнөөс үл хамаараад ТХЗ биелэгдэж байна гэсэн үг. Тэгэхээр нийгмийн ухамсар соёлын хандлагын асуудлыг л зөв чиглүүлэх нь чухал байна.

Ярилцсанд баярлалаа.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 16/ХІ ӨДРИЙН БАЙДЛААР)



ДЭЛХИЙН ИХЭНХ ОРОНД ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО ЧАНГАРЧ ЭХЭЛЛЭЭ

The Economist сэтгүүлийн 2021 оны 9 дүгээр сарын 11-ний дугаарт гарсан “The global policy cycle” нийтлэлийг Та бүхэнд хүргэж байна.

Инфляцыг эдийн засагт цөөн тооны бараа, харин хэт их мөнгө байгаагийн үр дагавар гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, худалдан авагч талд хэт их мөнгө байгаа тул цөөн тооны бараанаас олж авахын тулд илүү өндөр үнэ төлөхөд бэлэн байна. Худалдагч талд цөөн тооны л бараа байгаа тул аль болох өндөр илүү үнээр зарахыг бодно. Үүний үр дагаварт үнийн өсөлт буюу инфляц нэмэгдэнэ.

Энэ үйл явдал (инфляц) 2021 онд дэлхийн өнцөг булан бүрт тохиож байна. Нийлүүлэлт хангалтгүй байгаагаас эрэлтийн сэргэлт нь үнийн өсөлтийг бий болгож, жилийн инфляц евро бүсэд 3%, Америкт 4% гаруй, Бразилд 9%-иас дээш гарлаа. Энэхүү үнийн өсөлтийн дарамт, эдийн засгууд сэргэлт нь бодлого боловсруулагчдыг дэмжлэгийн арга хэмжээнүүдээ бууруулах, зогсооход хүргэж байна. Ихэнх оронд төсвийн дэмжлэгээ бууруулж байгаа бөгөөд төв банкууд бодлогоо чангаруулж эхэлсэн эсвэл ойрын үед чангаруулахаар зэхсэн байдалтай байна.

Зураг 1.

Засгийн газрын төсвийн алдагдал* (Потенциал ДНБ-д эзлэх хувиар)

■ 2020 он ■ 2021 оны таамаглал ■ 2022 оны таамаглал



Composite purchasing-managers' index^ (Өмнөх сартай харьцуулсан)



*Cyclically adjusted primary balance


^Based on surveys of purchasing managers in manufacturing and services

Эх сурвалж: IHS Market; IMF

Гэхдээ цар тахлын үед нөхцөл байдал хурдан өөрчлөгдөж болно. Иймд, Коронавирусын Дельта хувилбар эрчимтэй тархахын хэрээр эдийн засгийн өсөлт буурах нөхцөл байдал үүсэх тохиолдолд бодлогыг “хэвийн горимд” шилжүүлэх нь нэг төрлийн эрсдэл юм гэсэн болгоомжлолтой байна.

Засгийн газрууд цар тахлын үед үзүүлж байсан дэмжлэгүүдээ бууруулж байна. Европын Холбооны хувьд 2020 онд тохиролцсон 750 тэрбум еврогийн (886 тэрбум доллар) эдийн засгийг сэргээх сангийн зарцуулалт дөнгөж эхэлж байна. Гэсэн хэдий ч төсвийн бодлогын тэлэлт маш бага байна. Их-20 буюу G20-ийн бүлгийн эдийн засгуудад (хүүгийн төлбөрийг хасч, эдийн засгийн мөчлөгөөр тохируулга хийсэн) төсвийн алдагдал ирэх онд 2021 онтой харьцуулахад хоёр дахин буурах төлөвтэй байна (Зураг 2-ыг үзнэ үү).

Зураг 2



Америкт ажилгүйдлийн яаралтай тэтгэмж 9-р сарын 6-аас зогссон. Брукингс Институтээс ДНБ-ий өсөлтөд засгийн газрын оруулсан хувь нэмрийг 2021 оны эхний улирал дахь жилд шилжүүлсэн өсөлтийн хувьд 7.8 нэгж хувь, харин гуравдугаар улиралд 2.1 нэгж хувь байсан гэж тооцжээ. Их Британийн өндөр өртөгтэй хөдөлмөр эрхлэлтийн нөхөн олговрын схем энэ сарын сүүлээр дуусна. Эдгээр хоёр улсын засгийн газар төсвийн зарлагаа нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа ч, татвараа нэмэгдүүлэх замаар үүнийг санхүүжүүлэх, энэ нь эрэлтийн хэт өсөлтийг саармагжуулахад тусална гэж харж байна.

Мөнгөний бодлого ч мөн адил чангарах чиглэл рүүгээ явж байна. Энэ нь Бразил, ОХУ зэрэг хурдацтай хөгжиж буй орнуудад илт харагдаж байгаа бөгөөд хоол хүнс, эрчим хүчний үнэ эрс өсч, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан Төв банкууд бодлогын хүүгээ хэд хэдэн удаа өсгөсөн байна. Эдгээр улс орнууд өмнө нь өндөр инфляцын дарамттай хэдэнтэй нүүр тулж, хүнд нөхцөл байдлыг мэдэрсэн, тиймээс одоо инфляцыг онилдог мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг, инфляцын хүлээлтийг удирдахад ихээхэн анхаарч буй улс орнууд юм. БНСУ өнгөрсөн 8-р сарын 25-нд 2018 оноос хойш анх удаа бодлогын хүүгээ нэмсэн байна. Норвеги улс ч мөн адил бодлогын хүүгээ нэмэх шийдвэрийг гаргах төлөвтэй байна. Харин Шинэ Зеландын Нөөцийн банк наймдугаар сард бодлогын хүүгээ өсгөнө гэж таамаглаж байсан хэдий ч тус улсад Ковид-19 тархалт эрчимтэй нэмэгдснээс шалтгаалан хойшлуулжээ.

Өндөр хөгжилтэй орнуудад бодлогын хүүний өсөлт хамгийн эртдээ ирэх оны эцэс хүртэл гарахгүй. Учир нь бодлогын хүүгээ өсгөж эхлэхээс өмнө тэд хөрөнгө худалдаж авч, эдийн засагт мөнгө шууд нийлүүлж байгаа үйл ажиллагаагаа зогсоох ёстой. Гэхдээ хөрөнгийн худалдан авалт хийж эх үүсвэр олгохоо аажмаар хааж байна. Тухайлбал, Австралийн Нөөцийн банк 9-р сарын 7-ны өдрийн хурлын дараа активын худалдан авалтаа багасгаж эхэлсэн бөгөөд Английн Төв банк удахгүй 875 тэрбум фунт стерлинг буюу 1.2 триллион долларын үнэт цаас худалдан авах зорилтоо биелүүлж дуусах болно.

Европын төв банк 9-р сарын 9-нд болсон уулзалтаараа бонд худалдан авах схемийн дагуу хийсэн хөрөнгийн худалдан авалт хийх хурдыг бууруулж байгаагаа зарлав. Харин Америкт 8-р сарын байдлаар ажил эрхлэлтийн статистик сул гарсан нь Холбооны нөөцийн банк хөрөнгө худалдан авахаа сааруулж эхлэхээ зарлах хугацааг хойшлуулж магадгүй боловч, хамгийн ихдээ хоёр сараар л хойшлогдох төлөвтэй байна. Хэдийгээр төв банкны ажилтнууд хөрөнгө худалдан авах явц удаашрах нь бодлогын чангаралт биш гэж байнга хэлдэг ч, энэ нь

бондын өгөөжийг өсгөхөд аль хэдийн түлхэц үзүүлж эхлээд байна.

Оны эхээр эдийн засгууд хурдацтай сэргэхээр хүлээгдэж байв. Гэвч Коронавирусын Дельта хувилбар эрчимтэй тархах тусам улс орнуудын эдийн засгийн өсөлт хүлээгдэж байсан түвшиндээ гарч чадахгүй байх эмзэг байдал нэмэгдэж байна. Зүүн өмнөд Азид цар тахлаас үүдэн эдийн засгийн хувьд хүнд зун болсон билээ. Учир нь ихэнх үйлдвэрүүд ажиллаагүй хаагдсан нь бусад улс руу чиглэсэн эд ангиудын урсгалыг тасалдуулж, үйл ажиллагааг улам дордуулжээ. Ковид-19-ийн халдварын тархалтад Америкийн эдийн засаг ч ганхаж байгаа бөгөөд гуравдугаар улирлын ДНБ-ий өсөлтийн таамаг жил бүр 6%-иас дээш байдаг байсан бол энэ жил 4%-иас бага болсон байна. Хэрэв Дельтагийн тархалт өмнөхөөс бага буюу “азтай” байх тохиолдолд улс орнууд дахь эдийн засгийн бодлого чангарах хандлага нь инфляцыг багаар бууруулж, үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн сэргээх боломжийг олгоно. Өөр нэг хувилбар нь дэлхийн эдийн засгууд Дельта хувилбартай нүүр тулж, хатуу хөл хорио тавигдаж, эргээд эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх юм.

ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2021 оны эхний 10 сарын эцсийн байдлаар Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр нийт 868.5 тэрбум төгрөгийн зээлийг 11.5 мянган өрхөд олгоод байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 2.3 дахин өссөн дүн юм.

Дүрслэл 1. Ипотекийн хөтөлбөрийн зээлийн дүн (тэрбум ₮) болон зээлдэгчийн тоо, сараар



Өнгөрсөн 4 жилд ипотекийн хөтөлбөрийн хүрээнд сард дунджаар 32.6 тэрбум төгрөгийн зээлийг олгож байсан бол 2021 онд сард дунджаар 84.4 тэрбум төгрөгийн зээлийг олгосон нь 2.2 дахин өндөр үзүүлэлт байлаа (Дүрслэл 1). Түүнчлэн, 2021 оны 11 болон 12 дугаар саруудад нийт Монголбанкнаас 70 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг банкуудад хуваарилж, холбогдох гэрээний дагуу банкууд өөрийн эх үүсвэрээр 46.7 тэрбум төгрөгийг нэмж, нийт тухайн 2 сард 116.7 тэрбум төгрөгийн ипотекийн хөтөлбөрийн зээлийг олгохоор ажиллаж байна.

Мөн нэг талаас хөтөлбөрийн ач холбогдолыг харгалзан үзэж, нөгөө талаас холбогдох эрх зүйн баримт бичгийн дагуу Монголбанкнаас хөтөлбөрийг 2023 онд багтаан Засгийн газарт шат дараатай шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд энэ хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж ажиллах юм.

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2021/11/19-ний хооронд 3,194.4 сая ам.долларын болон 178.4 сая юанийн нийт 1845 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.




График 1. 2018-2021 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)




График 2. 1990-2021 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)




График 3. 2021 оны 10 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)



ӨСВӨР НАСНЫХНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГ БОЛОВСРОЛ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШНЭЭС ХАМААРЧ БАЙНА



Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн байгууллага (OECD)-аас олон улсын хэмжээн дэх өсвөр насны хүүхдүүдийн санхүүгийн боловсролыг үнэлэх хөтөлбөр (PISA)-ийн хүрээнд 2018 онд хийгдсэн судалгааны үр дүнг та бүхэнд хүргэж байна.

ЭЗХАХБ-аас гишүүн болон гишүүн бус орны өсвөр насныхны мөнгө, хувийн санхүүгийн талаарх мэдлэг, ур чадварыг үнэлэх зорилготой 3 жилд нэг удаа явуулдаг судалгаа сүүлийн байдлаар 2018 онд хийгджээ. Тус судалгаанд 15 настай 117 мянга гаруй хүүхдийг хамруулжээ. Тэднээс банкны данс болон дебит карттай харьцах, зээлийн хүүний талаарх ойлголт, гар утас ашиглан банк санхүү, цахим худалдааны үйлчилгээнүүдээс сонголт хийх тухай асуулгаар түүвэр судалгаа авсан байна. Судалгааны ерөнхий үр дүнгээс үзэхэд, судалгаанд түүврээр хамруулсан гишүүн бус 20 орноос өсвөр насны 4 хүүхэд бүрийн нэг нь, гишүүн 13 орны 7 өсвөр насны хүүхэд бүрийн нэг нь өдөр тутмын зардлын шийдвэр гаргах чадвар хангалтгүй байна гэсэн үр дүн гарчээ.

Ер нь ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад дунджаар 10 сурагч тутмын нэг нь санхүүгийн мэдлэгийн түвшин хангалттай хэмжээнд буюу амьдрал дээр санхүүгийн шийдвэр гаргах чадвартай байдаг гэж үздэг байна.

Уг түүвэр судалгаанд оролцсон орнуудаас Эстони хамгийн өндөр оноог авсан бол Финланд, Канад, Польш, Австрали улс удаалжээ.

Энэхүү түүвэр судалгааны үр дүнгийн үзүүлэлтэд 2015 онд хийгдсэн PISA үнэлгээний үр дүнтэй ижил төстэй талууд цөөнгүй гарчээ. Тухайлбал хүйсийн ялгаа санхүүгийн боловсролд бага байгаа ч хандлага, зан үйлээс хамаараад санхүүгийн боловсролын байдал ялгаатай байна. Нөгөө талаас тухайн улсын нийгэм эдийн засгийн таатай нөхцөл нь өсвөр насныхны санхүүгийн мэдлэгийн түвшин өндөр байхад нөлөөлөх магадлалтай гэж үзжээ.

Түүнчлэн ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад дунджаар өсвөр насны хоёр хүүхэд тутмын нэг нь санхүүгийн байгууллагад данстай эсвэл төлбөрийн болон дебит карт эзэмшдэг. Гэсэн хэдий ч ойролцоогоор өсвөр насны гурван хүүхдийн нэг нь л банкны хуулгыг тайлбарлах, үнэлэх чадвартай байдаг гэсэн үр дүн гарчээ.

Энэхүү 2018 оны түүвэр судалгаанд өсвөр насны хүүхдүүдийн мөнгөтэй холбоотой сувгуудыг судлах, ялангуяа мөнгөтэй холбоотой хандлага, зан үйлийг дүрслэх, дижитал санхүүгийн үйл ажиллагааг судлах чиглэлүүдээр асуулга нэмэгдсэн нь агуулга ач холбогдлын хувьд өмнөх 2015 оны судалгаанаас ахисан үзүүлэлт болжээ.

Дээрх судалгаад дараах улсууд хамрагджээ. Австрали, Бразил, Болгар, Канадын мужууд (Британийн Колумб, Манитоба, Нью-Брансвик, Ньюфаундленд ба Лабрадор, Нова Скотиа, Онтарио ба хунтайж Эдвард арал), Чили, Эстони, Финланд, Гүрж, Индонез, Итали, Латви, Литва, Перу, Польш, Португал, ОХУ, Серби, Словак, Испани, АНУ.

Эх сурвалж: <https://www.oecd.org/finance/many-15-year-olds-struggle-with-financial-literacy-according-to-oecd-pisa-report.htm>

ОУ-ын өсвөр насны хүүхдүүдийн санхүүгийн боловсролыг үнэлэх хөтөлбөр (PISA)-ийн хүрээнд 2018 онд хийгдсэн судалгааны зарим үр дүн

Өсвөр насны хүүхдүүдийн 94 % нь

мөнгөний ач холбогдлын талаарх ойлголтыг эцэг, эхээсээ авдаг.

Багадаа 10 өсвөр насны хүүхдүүдээс 8 нь санхүүгийн өдөр бүр тутмын нарийн харилцааны ач холбогдлыг ойлгож мэддэг.



Өсвөр насны хүүхдүүдийн

54 % нь банк санхүүгийн байгууллагад мөнгөө байршуулдаг.



45 % нь төлбөрийн карт эсвэл дебит карт эзэмшдэг.



45 %

нь ямар нэгэн байдлаар цахим худалдаанд оролцсон.



(гэр бүлийн гишүүдтэй эсвэл ганцаараа) сүүлийн 12 сарын хугацаанд

39 %

гар утас ашиглан төлбөр тооцоо гүйцэтгэдэг.





МОНГОЛБАНК
ЭДИЙН ЗАСГИЙН
СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН
НӨӨЦИЙН УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГАЗАР

2021 он

**САРЫН ИНФЛЯЦИЙН ТҮҮХЭН МЭДЭЭЛЭЛТЭЙ
КАЛЕНДАРЬ**

1 сар						
(1.39%), [1.38%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

2-р сар						
(1.59%), [1.15%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28

3-р сар						
(1.18%), [0.93%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				

4-р сар						
(2.15%), [1.48%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30		

5-р сар						
(1.65%), [1.09%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30
31						

6-р сар						
(0.24%), [0.29%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30				

7-р сар						
(-0.30%), [0.11%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

8-р сар						
(-0.95%), [-0.26%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30	31					

9-р сар						
(-0.46%), [-0.32%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30			

10-р сар						
(0.22%), [0.40%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

11-р сар						
(0.76%), [0.75%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30		

12-р сар						
(0.93%), [0.87%]						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30
31						

¹ Энэ календарь нь 1997 оны 1-р сараас 2021 оны 9-р сар хүртэлх хугацаан дахь инфляцын сар бүрийн геометр дундаж өсөлтийн хувийг агуулсан болно.

² () дотор 1997 хойших сарын инфляцын геометр дунжийг, [] дотор голч буюу медианыг харуулсан.

³ Өнгөөр тухайн сарын инфляцын түүхэн дундаж өсөлт болон бууралтыг илэрхийлсэн.

-0.92%	-0.49%	-0.40%	0.16%	0.18%	0.70%	1.03%	1.27%	1.38%	1.59%	1.81%	2.35%
--------	--------	--------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

2022

ШИНЭ ЖИЛИЙН
МЭНД ХҮРГЭЭ!

MERRY CHRISTMAS AND
HAPPY NEW YEAR

